



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

#### **“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮНДСЭН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ЯВАГДААГҮЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “ЭРДЭС МОНГОЛ” ХХК-ИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД: ГАГ-2018/11-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир

Утас: 263755, цахим хаяг: [munkh-ochirb@audit.gov.mn](mailto:munkh-ochirb@audit.gov.mn)

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805, цахим хаяг: [saruulb@audit.gov.mn](mailto:saruulb@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Долгорсүрэн

Утас: 262451, цахим хаяг: [dolgorsurenb@audit.gov.mn](mailto:dolgorsurenb@audit.gov.mn)

Ахлах аудитор Р.Цолмон

Утас: 261628, цахим хаяг: [tsolbonr@audit.gov.mn](mailto:tsolbonr@audit.gov.mn)

Аудитор М.Доржмаа

Утас: 261456, цахим хаяг: [dorjmaam@audit.gov.mn](mailto:dorjmaam@audit.gov.mn)

Аудитор И.Туяадарь

Утас: 261675, цахим хаяг: [tuyadarii@audit.gov.mn](mailto:tuyadarii@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2019 он



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголтод хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хоёрдугаар, аудитаар өгсөн албан шаардлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, “Эрдэнэс таван толгой” ХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Л.Оюун-Эрдэнэ/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Д.Сумъяабазар/, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /Н.Цэрэнбат/, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, “Эрдэнэс таван толгой” ХК-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн, Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig\_KherregiTushaal\2019\A Tushaal\1225GAG2.Docx

07145

|                                                                                                                                                                                               |           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| Товчилсон үгийн жагсаалт .....                                                                                                                                                                | 3         |
| Зураг, дүрслэлийн жагсаалт .....                                                                                                                                                              | 3         |
| Хүснэгтийн жагсаалт .....                                                                                                                                                                     | 3         |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл .....                                                                                                                           | 4         |
| Ерөнхий мэдээлэл .....                                                                                                                                                                        | 5         |
| <b>Бүлэг 1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үндсэн зорилго, чиглэлийн дагуу явагдаагүй, зохион байгуулалтын бүтэц оновчгүй, орон тоо хэт олон байна.....</b>                           | <b>6</b>  |
| “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үндсэн зорилго, чиглэлийн дагуу явагдаагүй байна .....                                                                                                 | 6         |
| “Эрдэнэс Монгол” ХХК урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиггүй ажиллаж иржээ .....                                                                                           | 7         |
| Стратегийн ач холбогдол бүхий ордоос төрд ногдох ашгийг төвлөрүүлээгүй байна .....                                                                                                            | 8         |
| Компанийн ТУЗ хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна .....                                                                                                                | 8         |
| Зохион байгуулалтын бүтцийг компанийн зорилго, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт тулгуурлан оновчтой тогтоогоогүй, орон тоо хэт олон байна .....                                                  | 10        |
| “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ байгуулагдсанаас хойш дотоод хяналтгүй ажиллажээ .....                                                                                                           | 11        |
| Орлогын эх үүсвэрийг дүрмийн дагуу бүрдүүлээгүй, замын хураамжийн орлогоор үйл ажиллагаагаа явуулж байна .....                                                                                | 11        |
| Компанийн үйл ажиллагаанд хамааралгүй 1.6 тэрбум төгрөгийг зардлыг санхүүжүүлсэн байна .....                                                                                                  | 12        |
| Худалдан авах ажиллагааны 90.6 хувь нь зам засвар болон боомтын үйл ажиллагаанд зарцуулж байна .....                                                                                          | 14        |
| Охин компаниудын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна .....                                                                                                 | 17        |
| Зарим охин болон хараат компаниудын санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй байна .....                                                                             | 19        |
| ТУЗ-ийн тогтоолоор толгой болон охин, хараат компаниудын 2016 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар дахин аудит хийлгэсэн боловч аудитын дүгнэлт гараагүй байна ..... | 21        |
| Компанийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаагүй, ил тод мэдээлээгүй байна .....                                                                                                     | 22        |
| Эдийн засгийн 2007-2017 оны үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийсэн боловч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шийдвэр гаргаагүй байна .....                                                             | 22        |
| <b>Бүлэг 2. “Эрдэнэс Монгол” ХХК төрийг төлөөлөх засаглалыг үр нөлөөтэй удирдаж чадаагүйгээс төлөвлөсөн ажлууд үр дүнд хүрээгүй байна .....</b>                                               | <b>23</b> |
| Охин болон хараат компаниудыг хөгжүүлэх бодлого бүрэн тодорхойлогдоогүйгээс бизнес төлөвлөлтийн уялдааг хангах тогтолцоо бүрдээгүй байна .....                                                | 23        |
| Төрийн өмчийн оролцоотой компаниудыг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн судалгаа хөгжлийн ажлын үр дүнд байгуулсан компаниуд үйл ажиллагаагаа явуулаагүй байна .....                                | 26        |
| Охин, хараат компаниудын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хууль, дүрэмд нийцүүлэн удирдаж чадаагүй, уул уурхайн технологи ашиглалт, дэд бүтэц, логикийг хөгжүүлэх ажил хийгдээгүй байна .....     | 26        |
| Төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж ажиллаагүй байна .....                                                                                       | 29        |
| Төрийн өмчийн оролцоотой компаниудтай байгуулсан менежментийн гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна .....                                                                             | 31        |
| Төрийн өмчийн оролцоотой компаниудын санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт, нэгдсэн бодлого байхгүй байна .....                                                             | 33        |
| Охин хараат компаниудын санхүү, хөрөнгийн удирдлага, хувьцааны хуваарилалт, ногдол ашгийн олголтыг үр дүнтэй удирдаж чадахгүй байна .....                                                     | 34        |
| Төрийн өмчийн оролцоотой компаниудад тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна .....                                                                                                    | 35        |
| <b>Дүгнэлт .....</b>                                                                                                                                                                          | <b>36</b> |
| <b>Зөвлөмж .....</b>                                                                                                                                                                          | <b>37</b> |
| <b>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ирүүлсэн санал .....</b>                                                                                                               | <b>38</b> |
| <b>УАГ-ын тайлбар .....</b>                                                                                                                                                                   | <b>41</b> |
| <b>“Эрдэнэс Монгол” ХХК-иас ирүүлсэн санал .....</b>                                                                                                                                          | <b>42</b> |
| <b>УАГ-ын тайлбар .....</b>                                                                                                                                                                   | <b>43</b> |
| <b>Хавсралтууд .....</b>                                                                                                                                                                      | <b>44</b> |
| Хавсралт 1. Дотоод хяналтаас өгсөн зөвлөмж, ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн талаарх судалгаа .....                                                                                                | 44        |
| Хавсралт 2. Дэд бүтэц, логикийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний биелэлтийн судалгаа .....                                                                                         | 45        |
| Хавсралт 3. Охин, хараат компаниудын зорилго, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа .....                                                                                               | 46        |

## Товчилсон үгийн жагсаалт

|        |                                                  |
|--------|--------------------------------------------------|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| АМГТГ  | Ашигт малтмал газрын тосны газар                 |
| БНХАУ  | Бүгд найрамдах хятад ард улс                     |
| ЗГХЭГ  | Засгийн газрын хэрэг эрхлэх газар                |
| ТӨХ    | Төрийн өмчийн хороо                              |
| ТУЗ    | Төлөөлөн удирдах зөвлөл                          |
| ТЭЗҮ   | Техник эдийн засгийн үндэслэл                    |
| УИХ    | Улсын Их Хурал                                   |
| УУХҮЯ  | Уул уурхай хүнд үйлдвэрийн яам                   |
| ҮАГ    | Үндэсний аудитын газар                           |
| ХК     | Хувьцаат компани                                 |
| ХХК    | Хязгаарлагдмал хариуцлагатай компани             |
| ЭХЯ    | Эрчим хүчний яам                                 |

## Зураг, дүрслэлийн жагсаалт

| Үзүүлэлт  | Тайлбар                                                                                    |
|-----------|--------------------------------------------------------------------------------------------|
| Зураг 1   | ТУЗ-тэй охин болон хараат компанийн толгой компанитай харилцах харилцаа                    |
| Зураг 2   | ТУЗ-гүй охин болон хараат компанийн толгой компанитай харилцах харилцаа                    |
| Дүрслэл 1 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны үйл ажиллагааны зардлын бүтэц                            |
| Дүрслэл 2 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016, 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажлын судалгаа      |
| Дүрслэл 3 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн замын орлого болон нүүрсний зах зээлийн үнийн судалгаа            |
| Дүрслэл 4 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниудын 2016-2017 оны цэвэр ашгийн судалгаа |

## Хүснэгтийн жагсаалт

| Үзүүлэлт   | Тайлбар                                                                                                                                                         |
|------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүснэгт 1  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниуд, тэдгээрт харьяалагдах компаниудын судалгаа                                                                |
| Хүснэгт 2  | УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан ордууд                                                    |
| Хүснэгт 3  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд заасан үндсэн болон үйл ажиллагааны судалгаа                                                                                    |
| Хүснэгт 4  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны судалгаа                                                                                         |
| Хүснэгт 5  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн газар, нэгжийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг, орон тооны судалгаа                                                                       |
| Хүснэгт 6  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2008-2018 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, орон тооны судалгаа                                                                          |
| Хүснэгт 7  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016-2017 оны орлого, зардлын гүйцэтгэл                                                                                                |
| Хүснэгт 8  | Охин болон хараат компаниас авах зээл болон зээлийн хүүгийн авлагын судалгаа                                                                                    |
| Хүснэгт 9  | Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн судалгаа                                                                                                                 |
| Хүснэгт 10 | Замын засвар арчлалтад зарцуулсан хөрөнгийн судалгаа                                                                                                            |
| Хүснэгт 11 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны судалгаа                                                                                            |
| Хүснэгт 12 | Худалдан авах болон хэрэгжүүлэх арга хэмжээний судалгаа                                                                                                         |
| Хүснэгт 13 | “Багануур” ХК-ийн 2016-2017 оны ХАА-ны төлөвлөгөө                                                                                                               |
| Хүснэгт 14 | ҮАГ-аас “Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компаниудын санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын судалгаа                                                 |
| Хүснэгт 15 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниудын санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, аудит хийгдээгүй компаниудын судалгаа |
| Хүснэгт 16 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниудын санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, аудит хийгдээгүй компаниудын судалгаа |
| Хүснэгт 17 | Толгой болон охин, хараат компаниудын 2016 оны санхүүгийн аудитын дүгнэлтийн судалгаа                                                                           |
| Хүснэгт 18 | Охин болон хараат компаниудын зорилго, зорилтын судалгаа                                                                                                        |
| Хүснэгт 19 | Толгой болон ТУЗ-тэй охин болон хараат компаниудын дүрмийн давхардсан заалтын судалгаа                                                                          |
| Хүснэгт 20 | Бизнес төлөвлөгөөний орлого, зардлын судалгаа                                                                                                                   |
| Хүснэгт 21 | Боомтод хийгдсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын судалгаа                                                                                                 |
| Хүснэгт 22 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2009-2018 онд байгуулсан охин болон хараат компаниудын судалгаа                                                                        |
| Хүснэгт 23 | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016-2018 оны менежментийн төлбөрийн авлагын судалгаа                                                                                  |
| Хүснэгт 24 | Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх судалгаа                                                                                             |
| Хүснэгт 25 | Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн дэд бүтцийн судалгаа                                                                                          |

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл**

### **Аудит хийх үндэслэл:**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан УАГ-ын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **Аудитын зорилт:**

“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголтод аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилгоор дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх,
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх.

### **Аудитын хамрах хүрээ:**

Аудитад “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн техник, эдийн засгийн үндэслэл, 2016, 2017 оны үйл ажиллагааны болон уулын ажлын төлөвлөгөө, тайлан болон түүврийн аргаар сонгогдсон санхүүгийн баримт материалууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Улсын бүртгэл, оюуны өмчийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, орон нутгийн засаг, захиргааны нэгж зэрэг байгууллагуудыг хамруулав.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг АДБОУС-300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, тоо баримтыг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### **Аудитад ашигласан шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Татварын ерөнхий хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Хөрөнгө оруулалтын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Бусад

### **Хүндрэл бэрхшээл:**

“Эрдэнэс Монгол” ХХК-д бүтцийн өөрчлөлт ойр ойрхон хийгдсэнээс шалтгаалан зохион байгуулалтын газар, нэгжүүд байнга өөрчлөгдөж, удирдлага, ажил хариуцсан мэргэжилтнүүд солигдсон болон хийгдсэн ажлын баримт материалыг олж авахад хүндрэлтэй байлаа.

Тус компанид архивын өрөө байхгүй гэсэн шалтгаанаар 2016, 2017 оны баримтуудыг архивд хүлээж аваагүйгээс аудитад шаардлагатай баримт бичгүүдийг олж авахад хүндрэл учирч, аудитыг гүйцэтгэх хугацаа алдах нөхцөлийг үүсгэсэн.

## Ерөнхий мэдээлэл

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т “*стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд*” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордуудыг хамруулахаар тодорхойлсон байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 266 дугаар тогтоолыг үндэслэн “*Стратегийн ач холбогдол бүхий орд, улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулах, стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлж, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх, ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн мэдлийн хувьцааг борлуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх*” чиг үүрэгтэй “Эрдэнэс МГЛ” ХХК-ийг ТӨХ-ны 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор байгуулж, Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор компанийн нэрийг “Эрдэнэс Монгол” ХХК болгон өөрчилсөн байна.

“Эрдэнэс Монгол” ХХК 2018 оны 1 дүгээр сарын 01-ний байдлаар 9 охин, 3 хараат компанитай бөгөөд тэдгээрийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг 11 компанийг оруулбал нийт 23 компанитай байна.

**Хүснэгт 1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниуд, тэдгээрт харьяалагдах компаниудын судалгаа**

| төрөл                | №                | Охин болон хараат компаниудын нэрс                                 | Охин компаниудын эзэмшлийн компаниудын нэрс                  |
|----------------------|------------------|--------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|
| “Эрдэнэс Монгол” ХХК | Охин компаниуд   | 1 “Эрдэнэс Оюу толгой” ХХК /100/                                   | “Оюутолгой” ХХК /34/                                         |
|                      |                  | 2 “Эрдэнэс таван толгой” ХК /65.2/                                 | “Гашуун Сухайт автозам” ХХК /40/                             |
|                      |                  | 3 “Багануур” ХК /75/ “Монголиан нэшнл коал корпораашн” ХХК /21.06/ | “Багануур Сувилал” ХХК /100/                                 |
|                      |                  |                                                                    | “Багануур Илч” ХХК /100/                                     |
|                      |                  |                                                                    | “Мон цахим” ХХК /34/                                         |
|                      |                  | 4 “Шивээ Овоо” ХК /90/ Иргэд /10/                                  | “Шивээ Сервис” ХХК /100/                                     |
|                      |                  | 5 “Мон-Атом” ХХК /100/                                             | “Бадрах Энержи” ХХК /34/                                     |
|                      |                  |                                                                    | “Мон Чех Ураниум” ХХК /51/                                   |
|                      |                  |                                                                    | “Гурван сайхан” ХХК /15/                                     |
|                      |                  |                                                                    | “Төв Азийн уран” ХХК /21/                                    |
|                      | Хараат компаниуд | 6 “Эрдэнэс Метан” ХХК /100/                                        | “Эрдэнэс Газ анд Энержи” ХХК /34/,<br>“Алтай групп” ХХК /66/ |
|                      |                  | 7 “Эрдэнэс Ассет менежмент” ХХК /100/                              |                                                              |
|                      |                  | 8 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК /100/                                   |                                                              |
|                      |                  | 9 “Таван толгой түлш” ХХК /100/                                    |                                                              |
|                      |                  | 1 “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК /50/, “Шинэ шивээ” ХХК /50/           |                                                              |
|                      |                  | 2 “Эрдэнэс Ашид” ХХК /34/ “МАК” ХХК /66/                           |                                                              |
|                      |                  | 3 “Эрдэнэс Стийл” ХХК /50/ “Бэрэн групп” ХХК /50/                  |                                                              |



## Бүлэг 1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үндсэн зорилго, чиглэлийн дагуу явагдаагүй, зохион байгуулалтын бүтэц оновчгүй, орон тоо хэт олон байна

### “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа үндсэн зорилго, чиглэлийн дагуу явагдаагүй байна

1.1. Засгийн газрын 2006 оны 266 дугаар тогтоолыг үндэслэн ТӨХ-ны 2007 оны 52 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг дараах 4 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан боловч 3 зорилго нь эхлэл төдий хэрэгжиж, 1 зорилго огт хэрэгжээгүй байна.

#### Эхлэл төдий хэрэгжсэн 3 зорилго:

1. “Эрдэнэс Монгол” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий орд, улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулах зорилгын хүрээнд УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ордод хамааруулсан улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон 10 ордын тусгай зөвшөөрлийг эзэмших ёстой байна. Гэтэл 2018 оны 9 дүгээр сарын байдлаар Говь сүмбэр аймгийн Шивээ говь дахь 4293 гектар талбай бүхий хүрэн нүүсний ордын 3 талбайг 30 жил ашиглах ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл, /13111А, 13112А, 13113А/-ийг эзэмшиж байна.

#### Хүснэгт 2. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан ордууд

| д/д             | Ордын нэр      | Байршил                | Ашигт малтмалын төрөл | Хайгуул хийсэн байдал |                  | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшсэн тусгай зөвшөөрлийн тоо |
|-----------------|----------------|------------------------|-----------------------|-----------------------|------------------|----------------------------------------------------------|
|                 |                |                        |                       | Улсын хөрөнгөөр       | Хувийн хөрөнгөөр |                                                          |
| 1               | Багануур       | Улаанбаатар, Багануур  | Хүрэн нүүрс           | 1                     |                  | 3                                                        |
| 2               | Шивээ-Овоо     | Говь сүмбэр, Шивээговь | Хүрэн нүүрс           | 1                     |                  |                                                          |
| 3               | Мардай         | Дорнод, Дашбалбар      | Уран                  | 1                     |                  |                                                          |
| 4               | Дорнод         | Дорнод, Дашбалбар      | Уран                  | 1                     |                  |                                                          |
| 5               | Гурван булаг   | Дорнод, Дашбалбар      | Уран                  | 1                     |                  |                                                          |
| 6               | Төмөртэй       | Сэлэнгэ, Хүдэр         | Төмрийн хүдэр         | 1                     |                  |                                                          |
| 7               | Оюу толгой     | Өмнөговь, Ханбогд      | Зэс, молибдени        |                       | 1                |                                                          |
| 8               | Цагаан суварга | Дорноговь, Мандах      | Зэс, молибдени        | 1                     |                  |                                                          |
| 9               | Эрдэнэт        | Орхон, Баян-Өндөр      | Зэс, молибдени        | 1                     |                  |                                                          |
| 10              | Бүрэнхаан      | Хөвсгөл, Алаг- Эрдэнэ  | Фосфорит              | 1                     |                  |                                                          |
| 11              | Бороо          | Сэлэнгэ, Баянгол       | Алт                   | 1                     |                  |                                                          |
| 12              | Төмөртэйн Овоо | Сүхбаатар, Сүхбаатар   | Цайр, хар тугалга     | 1                     |                  |                                                          |
| 13              | Асгат          | Баян-Өлгий, Ногооннуур | Мөнгө                 | 1                     |                  |                                                          |
| 14              | Нарийн сухайт  | Өмнөговь, Гурвантэс    | Нүүрс                 |                       | 1                |                                                          |
| 15              | Таван толгой   | Өмнөговь, Цогтцэций    | Чулуун нүүрс          | 1                     | 1                |                                                          |
| 16              | Гацуурт        | Сэлэнгэ, Мандал        | Алт                   |                       | 1                |                                                          |
| <b>Нийт дүн</b> |                |                        |                       | <b>13</b>             | <b>4</b>         | <b>3</b>                                                 |

Эх сурвалж: УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

2. Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн мэдлийн хувьцааг борлуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/116 дугаар тушаалаар “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн эзэмшлийн хувьцааны бүртгэлийг цэцэглж, санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулж, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 15.0 тэрбум ширхэг хувьцааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид бүртгүүлсэн;
- Гүйцэтгэх захирлын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн А/62 дугаар тушаалаар “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах асуудлыг судалж, бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг томилсон боловч ажил амжилттай болоогүй байна;
- Гүйцэтгэх захирлын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/108 дугаар тушаалаар “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн хувьцааг бүртгэх тухай шийдвэрийг гаргаж, бүртгүүлсэн байна.

3. Ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх зорилгын хүрээнд Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд газарт “Шинэ Шивээ” ХХК-ийн 2007-2012 онд хийж гүйцэтгэсэн нөөцийн тайлан мэдээг авч мэдээллийн санг бүрдүүлэх, ордын нөөцийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, дүгнэлт гаргах ажлыг 2017 оны 2 дугаар сард гүйцэтгэсэн байна.

#### Хэрэгжээгүй зорилго:

4. “Эрдэнэс Монгол” ХХК стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлж, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх зорилго огт хэрэгжээгүй, 2007 оноос хойш нэг ч удаа ногдол ашиг төвлөрүүлээгүй байна.

1.2. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ”, 8.3-т “Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн дүрмийг Компанийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газар батална” гэж заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм”-ийг баталжээ.

1.3. УИХ-аас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр “Хүний хөгжил сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай” хуулиар 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус хуулийг хүчингүй болгож, мөн өдрөөс эхлэн мөрдөхөөр баталсан “Ирээдүйн өв сангийн тухай хууль” болон “Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд “Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газар шинэчлэн батална” гэж заасныг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 6 дугаар тогтоолоор тус компанийн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, тайланг 3 дугаар сарын 15-ны дотор танилцуулах үүрэг өгсөн боловч өнөөдрийг хүртэл компанийн дүрэм шинэчлэгдээгүй, хуучин дүрэм хүчинтэй байна.

1.4. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2007 оноос хойш мөрдөж байсан дүрмүүдэд тус компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг харилцан адилгүй тодорхойлсон байна.

#### Хүснэгт 3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд заасан үндсэн болон үйл ажиллагааны судалгаа

| Дүрмийг баталсан газар, тогтоолын огноо, дугаар                                  | Үндсэн үйл ажиллагааны тоо | Нийт үйл ажиллагааны тоо |
|----------------------------------------------------------------------------------|----------------------------|--------------------------|
| ТӨХ-ны 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоол                    | 2                          | 12                       |
| Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 167 дугаар батлагдсан дүрэм  | 3                          | 9                        |
| Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 347 дугаар батлагдсан дүрэм | 8                          | 33                       |
| Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны 104 дугаар батлагдсан дүрэм         | 9                          | 31                       |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмүүд

1.5. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016-2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 203 ажлын **38.4** хувь буюу 78 нь тус компанийн үндсэн зорилгын хүрээнд гүйцэтгэх ажлууд, **15.3** хувь буюу 31 нь авто зам, дэд бүтэц бий болгох, шинэ төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой ажлууд, **46.3** хувь буюу 94 нь компанийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаатай холбоотой ажлууд эзэлж байгаагаас харахад тус компани байгуулагдсан зорилгын хүрээнд ажиллаж чадаагүйг харуулж байна.

#### “Эрдэнэс Монгол” ХХК урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиггүй ажиллаж иржээ

1.6. Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.1-т “компани болон охин компанийн стратегийн зорилго, зорилт, хөрөнгө оруулалтын бодлого, богино, дунд болон урт хугацааны бизнес төлөвлөгөө, төсвийг батлах” гэж заасныг огт хэрэгжүүлээгүй, компани байгуулагдсанаас хойш урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаагүй байна.

1.7. Энэ нь тус компани байгуулагдсан зорилгыг биелүүлэх боломжийг алдагдуулж, үйл ажиллагаа үндсэн чиг үүргээс гажихад хүргэсэн бөгөөд аудитын явцад тус компанийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байхгүй байгаагаас шалтгаалан төрөөс баримтлах бодлогод нийцсэн эсэхийг тодорхойлох боломж бүрдсэнгүй.



**Стратегийн ач холбогдол бүхий ордоос төрд ногдох ашгийг төвлөрүүлээгүй байна**

1.8. “Эрдэнэс Монгол” ХХК байгуулагдсанаас хойш дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Компани байгуулагдсанаас хойш 25.8 тэрбум төгрөг, нэгдлийн хэмжээнд 877.4 тэрбум төгрөгийн татвар, хураамж, бусад төлбөрийг улсын төсөвт төлсөн байна.

Тухайлбал:

- Засгийн газрын 2011 оны 348 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2011 оны 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийг байгуулж, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу Толгойн зэс-алтны ордыг ашиглах төсөл хэрэгжиж эхэлснээс хойш татвар, хураамж болон бусад төлбөрт нийт 0.9 тэрбум төгрөг;
- УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс таван толгой” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулснаас хойш татвар, хураамж, бусад төлбөрт нийт 696.6 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Засгийн газартай байгуулсан 2011 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн урьдчилгаа төлбөрийн гэрээг үндэслэн 2011, 2012 онд арилжааны банкны зээлээр 118.9 тэрбум төгрөг, “Чалко” компанийн урьдчилгаа төлбөрөөс 297.1 тэрбум төгрөг, нийт 416.0 тэрбум төгрөгийг Хүний хөгжил санд төвлөрүүлж, Монгол Улсын иргэн бүрд хувь хишиг болгон олгуулсан байна.

**Компанийн ТУЗ хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна**

1.9. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлага улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан байнга солигдсоноос Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.10. ТӨХ-ны 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоолоор “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн ТУЗ-ийн дарга анх томилогдсоноос хойш 9 удаа солигджээ. Тухайлбал:

- ТӨХ-ны 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Д.Сугар;
- Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 167 дугаар тогтоолоор Б.Заяабал, /Б.Шинэбаатар, Ч.Сайнбилэг, Ц.Нанзаддорж/;
- Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 47 дугаар тогтоолоор ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Ш.Солонго;
- ТУЗ-ийн 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Д.Ганболд;
- ТУЗ-ийн 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Б.Даажамба;
- ТУЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 1 тогтоолоор Б.Бат-Эрдэнэ.

1.11. Тус компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ТӨХ-ны 2007 оны 53 дугаар тогтоолоор 7, Засгийн газрын 2012 оны 167 дугаар тогтоолоор 9, Засгийн газрын 2016 оны 331 дүгээр тогтоолоор 6 гишүүнийг нэр заан томилж байсныг Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 65 дугаар тогтоолоор дараах албан тушаалтнаар томилохоор өөрчилжээ. Үүнд:

- ЗГХЭГ-ын Дэд дарга, /Б.Даажамба/
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, /Ц.Цэнгэл/
- ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, /Б.Ганбат, Э.Бат-Идэр/
- Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, /Э.Алтанзул/
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, /Д.Батхүү, Ч.Анун/
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Бямбасайхан, Ц.Түмэнцогт/

1.12. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ нь Засгийн газрын 2014 оны 9 дүгээр тогтоолоор компанийн нэрийг “Эрдэнэс Монгол” ХХК болгон өөрчилсөн байхад ТУЗ-ийн 2012 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлээгүй, 2017 он хүртэл мөрдөн ажиллажээ.

1.13. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ нь 2016 онд 10 удаа хуралдаж 49 тогтоол, 28 тэмдэглэл, 2017 онд 5 удаа хуралдаж 97 тогтоол, 5 тэмдэглэл гаргасан байна.

1.14. ТУЗ-ийн хурлаас 2016-2017 онд гаргасан нийт 147 шийдвэрийн 20 хувь нь томилгоотой, 18 хувь нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай, 14 хувь нь охин, хараат компанийн үйл ажиллагаатай, 13 хувь нь хяналт шалгалттай, 10 хувь нь дүрэм, журам батлахтай, 10 хувь нь төсөв, санхүүтэй, 7 хувь шинээр компани байгуулахтай, 5 хувь нь хөрөнгө оруулалт, хөрөнгө бэлтгэх, актлахтай, 3 хувь нь бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлууд эзэлж

байгаагаас үзэхэд тус компани байгуулагдсан зорилгын хүрээнд чиглэсэн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргаагүйг харуулж байна.

1.15. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т *“Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн ТУЗ нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна”*, Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т *“ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүнийг хувьцаа эзэмшигчийн хурал 3 жилийн хугацаагаар томилно”* гэсэн заалт Засгийн Газрын 2017 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 1 дүгээр тогтоолоос өмнө хэрэгжээгүй байна.

1.16. Энэ нь ТУЗ-ийн 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулахаас өмнө “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороог байгуулаагүй, Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т *“Компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг нийтэд нээлттэй зарлах, компанийн засаглал болон компанийн үйл ажиллагаанд холбоотой тодорхой салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас санал авах зэрэг арга замаар сонгон шалгаруулж, томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал хүргүүлнэ”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

1.17. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11-т *“компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах”*, Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.19-т *“ТУЗ нь жилд 1-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчид ажлаа тайлагнана”* гэж заасныг хэрэгжүүлээгүй, 2007 оноос хойш хувьцаа эзэмшигчдэд ажлаа нэг ч удаа тайлагнаагүй байна.

1.18. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7-д *“ТУЗ өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дараах хороодыг байгуулан ажиллуулах бөгөөд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно”*, 8.8-д *“Хороод нь тус бүр 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг ТУЗ-ийн гишүүдээс томилно”* гэж заасныг үндэслэн ТУЗ-ийн 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэд 4 хороог байгуулж, компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10-т *“Хорооны ажиллах журмыг Компанийн тухай хуульд нийцүүлэн ТУЗ батална”* гэж заасныг үндэслэн дор дурдсан журмуудыг баталсан байна. Тухайлбал:

- ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам”.
- ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”.
- ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам”.

1.19. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9-т *“Хороо хариуцсан асуудлаар ТУЗ-д санал, дүгнэлт оруулж хэлэлцүүлнэ”* гэж заасныг үндэслэн 2017 онд ТУЗ-ийн аудитын хороо 3 дүгнэлт, цалин урамшууллын хороо 1, төслийн удирдах хороо 1 дүгнэлт тус тус гаргасан байна.

1.20. Харин ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо байгуулагдсанаас хойш “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалт болон ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх “Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, 2016-2017 онд нэг ч дүгнэлт гаргаагүй байхад ТУЗ-өөс 2016-2017 онд томилгоотой холбоотой нийт 29 тогтоол гаргаж, дүрмийн заалтыг зөрчсөн байна.

**Зохион байгуулалтын бүтцийг компанийн зорилго, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт тулгуурлан оновчтой тогтоогоогүй, орон тоо хэт олон байна**

1.21. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал анх байгуулагдсанаас хойш 7 удаа солигдсон бөгөөд 0.9-3.1 жил хүртэлх хугацаанд ажилласан байна. Тухайлбал:

- Д.Зоригт /2007.02.22-ноос 2008.12.05 хүртэл 1.8 жил/
- Б.Энэбиш /2008.12.05-2012.01.05 хүртэл 3.1 жил/
- Я.Долгоржав /2012.01.05-2012.11.19 хүртэл 0.9 жил/
- О.Сайнбуян /2012.19-2015.02.04 хүртэл 2.2 жил/
- Б.Бямбасайхан /2015.02.04-2016.09.29 хүртэл 1.7 жил/
- Ц.Түмэнцогт /2016.09.29-2018.05.16 хүртэл 1.7 жил/
- П.Ганхүү /2018.05.28-нд томилогдсон/

1.22. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо 2007 оноос хойш 8 удаа өөрчлөгдөж, 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар анх батлагдсанаас 45 орон тоогоор буюу 2.4 дахин өссөн байна.

**Хүснэгт 4. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны судалгаа**

| № | Компанийн бүтэц, орон тоог баталсан ТУЗ-ийн тогтоол, огноо, дугаар | удирдах ажилтны тоо | газар, хэлтэс нэгжийн тоо | орон тоо | дүрэмд заасан үйл ажиллагааны тоо |
|---|--------------------------------------------------------------------|---------------------|---------------------------|----------|-----------------------------------|
| 1 | 2007 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 03                           | 2                   | 5                         | 37       | 12                                |
| 2 | 2012 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 05                            | 3                   | 7                         | 52       | 9                                 |
| 3 | 2013 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 14                            | 3                   | 10                        | 56       | 33                                |
| 4 | 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 22                            | 4                   | 13                        | 66       | 33                                |
| 5 | 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 07                            | 4                   | 4                         | 71       | 33                                |
| 6 | 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 37                           | 4                   | 9                         | 80       | 31                                |
| 7 | 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 40                           | 5                   | 12                        | 88       | 31                                |
| 8 | 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 51                           | 6                   | 12                        | 88       | 31                                |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолууд

1.23. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны “Компанийн зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх тухай” А/99 дүгээр тушаалаар батлагдсан газар, хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийг батлагдсан орон тоонд харьцуулахад дунджаар 1 мэргэжилтэн 1.4 ажил гүйцэтгэхээр ногддог, нийт орон тооны 24 хувь буюу 3 хүний нэг нь удирдах албан тушаалтан эзэлдэг зэргээс үзэхэд тус компанийн албан хаагчдын ажлын ачаалал бага байгааг илтгэж байна.

**Хүснэгт 5. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн газар, нэгжийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг, орон тооны судалгаа**

| Харьяалах удирдлага     | Газар, хэлтсийн нэр             |                                               | үндсэн чиг үүрэг |      | орон тоо |             |       | 1 ажилтанд ногдох ачаалал |
|-------------------------|---------------------------------|-----------------------------------------------|------------------|------|----------|-------------|-------|---------------------------|
|                         |                                 |                                               | тоо              | Нийт | удирдах  | мэргэжилтэн | нийт  |                           |
| Гүйцэтгэх захирал /1/   | Гүйцэтгэх захирлын ажлын алба   | Хуулийн хэлтэс                                | 8                | 8    | 1        | 6           | 7     | 1.3                       |
|                         |                                 | Хүний нөөцийн хэлтэс                          | 8                | 8    | 1        | 5           | 6     | 1.6                       |
|                         |                                 | Захираа, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс | 7                | 7    | 1        | 4           | 5     | 1.8                       |
|                         |                                 |                                               | 5                | 5    | 1        | 7           | 8     | 0.7                       |
| Тэргүүн дэд захирал /1/ | Үйл ажиллагааны газар /1/       | Уул уурхай, технологи                         | 9                | 11   | 2        | 7           | 15    | 1.3                       |
|                         |                                 | Дэд бүтэц, логистик                           | 2                |      | 1        | 5           |       | 0.4                       |
| Дэд захирал /1/         | Санхүүгийн удирдлагын газар /1/ | Санхүү                                        | 18               | 31   | 2        | 7           | 17    | 2.6                       |
|                         |                                 | Санхүүгийн үйл ажиллагааны аудит, мониторинг  | 7                |      | 1        | 2           |       | 3.5                       |
|                         |                                 | Хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт          | 6                |      | 1        | 4           |       | 1.5                       |
| Дэд захирал /1/         | Бизнес хөгжлийн газар /1/       | Бизнесийн төлөвлөлт                           | 6                | 9    | 2        | 4           | 13    | 1.5                       |
|                         |                                 | Судалгаа хөгжил                               | 3                |      | 1        | 6           |       | 0.5                       |
| Удирдлага               |                                 |                                               |                  |      | 4        |             | 4     |                           |
| НИЙТ ДҮН                |                                 |                                               | 79               | 79   | 18       | 57          | 75    | 1.4                       |
| эзлэх хувь              |                                 |                                               |                  |      | 24.0     | 76.0        | 100.0 |                           |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/99 дүгээр тушаал, ТУЗ-ийн тогтоолууд

1.24. Мөн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг батлагдсан орон тоонд харьцуулахад 2008-2018 онд дунджаар 1 хүн 0.43-3.88 буюу жилд 1 ажлыг 1 хүн гүйцэтгэсэн байгаа нь тус компанийн зохион байгуулалтын бүтэц оновчгүй, орон тоо илүүдэлтэйг нотолж байна.

**Хүснэгт 6. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2008-2018 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, орон тооны судалгаа**

| Үзүүлэлт             | Он   |      |      |      |      |      |      |      |      |      |      |
|----------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
|                      | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
| төлөвлөсөн ажлын тоо | 16   | 52   | 58   | 0    | 37   | 47   | 55   | 44   | 59   | 144  | 341  |
| батлагдсан орон тоо  | 37   | 37   | 37   | 37   | 52   | 56   | 66   | 71   | 80   | 80   | 88   |
| 1 хүнд ногдох ажил   | 0.43 | 1.41 | 1.57 | 0    | 0.71 | 0.84 | 0.83 | 0.62 | 0.74 | 1.8  | 3.88 |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, орон тоо баталсан шийдвэрүүд

1.25. Батлагдсан орон тоог цалингийн хүснэгтээр цалин авсан албан хаагчдын тоотой харьцуулж үзэхэд 2016 онд 201, 2017 онд 526, 2018 онд 282 хүнээр тус тус илүү байна.

1.26. Энэ нь компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоонд ТУЗ-ийн гишүүд, зөвлөх, гэрээт ажилтнууд, Азийн хөгжлийн банкны болон Үндэсний брэнддинг төслийн ажилтнуудыг оруулж батлаагүйтэй холбоотой байна.

1.27. Орон тоо илүүдэлтэй, албан хаагчдын ажлын ачаалал бага байхад дараах албан хаагчдыг ажиллуулж, үр ашиггүй зардлыг гаргажээ. Тухайлбал:

- Гэрээт ажилтан болон зөвлөхүүдэд 2016 онд нийт 145 хүнд 229.0 сая төгрөг, 2017 онд 190 хүнд 248.8 сая төгрөг, 2018 онд 132 хүнд 199.6 сая төгрөг, нийт 677.4 сая төгрөгийн цалин олгосон;
- Азийн хөгжлийн банк болон Үндэсний брэнддинг төслийн ажилтнуудыг авахгүйгээр компанийн үндсэн орон тооны албан хаагчдад нэмэлт чиг үүргээр хариуцуулан хийлгэх боломжтой байхад Азийн хөгжлийн банкны төслийн ажилтнуудад 2016 онд 51 хүнд 825.3 сая төгрөг, 2017 онд 180 хүнд 2,496.8 сая төгрөг, 2018 онд 82 хүнд 759.2 сая төгрөг, нийт 4,081.3 сая төгрөгийн, 2017 онд Үндэсний брэнддинг төслийн 137 ажилтанд 227.3 сая төгрөгийн цалин тус тус олгосон байна.

**“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ байгуулагдсанаас хойш дотоод хяналтгүй ажиллажээ**

1.28. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан зохион байгуулалтын бүтцээр ТУЗ-ын дэргэдэх “Дотоод хяналтын нэгж”-ийг бий болгож, дотоод хяналт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

1.29. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-өөс баталсан “Дотоод хяналтын нэгж”-ийн 2017 оны төлөвлөгөөг үндэслэн толгой болон охин, хараат нийт 11 компанийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар дараах нийтлэг зөрчил, дутагдлыг илрүүлж, зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна. **/Хавсралт 1/** Үүнд:

- Урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй;
- Засаглалыг хангалттай түвшинд хөгжүүлээгүйгээс ТУЗ-ийн шийдвэр гаргалт удаашралтай;
- Эрсдэлд суурилсан менежментийн арга барил хангалтгүй;
- Эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ огт хийдэггүй;
- Дотоод аудитыг Олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлээгүй;
- Группийн хэмжээнд мэдээлэл солилцоо, харилцан хамааралтай ажиллах тогтолцоо хангалтгүй;
- Ажиллагсдын ажилд орох, гарах урсгалаас шалтгаалан урт хугацааны бодлого, хариуцлагын систем маш сул;
- Охин компаниуд толгой компаниас санхүүжилт, хөрөнгө оруулалт хэлбэрээр зээл авч өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд зээлийн эргэн төлөлт, гаднаас санхүүжилт татах ажил удаашралтай.

**Орлогын эх үүсвэрийг дүрмийн дагуу бүрдүүлээгүй, замын хураамжийн орлогоор үйл ажиллагаагаа явуулж байна**

1.30. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн орлогын эх үүсвэрийг тус компанийн дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1<sup>1</sup>, 15.2<sup>2</sup>-т заасны дагуу зээл, хөрөнгө оруулалт, ногдол ашиг, хөрөнгийн өгөөж, хувьцаа борлуулсны орлого, менежментийн төлбөр зэргээс бүрдүүлэхээр байна.

<sup>1</sup> Компани нь зээл, хөрөнгө оруулалт, ногдол ашиг, хөрөнгийн өгөөж, хувьцаа борлуулсан орлогын эх үүсвэрээс санхүүжнэ

<sup>2</sup> Компани охин компанитайгаа менежментийн төлбөрийн гэрээ байгуулж, төлбөр авах бөгөөд төлбөрийн хэмжээг гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл батална



1.31. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор орлогыг 2016 онд 30,952.0 сая төгрөгөөр, 2017 онд 65,560.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2016, 2017 онд гүйцэтгэлээр нийт орлогын 84.3-88.3 хувь нь замын хураамжийн орлого эзэлж байна.

**Хүснэгт 7. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2016-2017 оны орлого, зардлын гүйцэтгэл /сая төгрөгөөр/**

| №                                 | Үндсэн үзүүлэлтүүд                         | 2016.12.31 |           |       | 2017.12.31 |           |       |
|-----------------------------------|--------------------------------------------|------------|-----------|-------|------------|-----------|-------|
|                                   |                                            | Төсөв      | Гүйцэтгэл | Хувь  | Төсөв      | Гүйцэтгэл | Хувь  |
| Нийт орлого                       |                                            | 30,952.0   | 33,780.8  | 109.1 | 65,560.8   | 64,245.9  | 98.0  |
| 1.1                               | Менежментийн төлбөр                        | 4,727.6    | 4,430.1   | 93.7  | 5,754.15   | 5,515.91  | 95.9  |
| 1.2                               | Шивээ Овоо ХК-ийн талбай ашигласны төлбөр  | 224.4      | 224.4     | 100.0 | 204.00     | 224.40    | 110.0 |
| 1.3                               | Замын хураамжийн орлого                    | 26,000.0   | 28,482.1  | 109.5 | 59,602.7   | 56,757.80 | 95.2  |
| 1.4                               | Бусад                                      | -          | 644.2     |       | -          | 1,747.81  |       |
| Үйл ажиллагааны зардал            |                                            | 30,723.2   | 25,742.9  | 83.8  | 57,047.2   | 42,797.1  | 75.0  |
| Гашуун сухайтын авто замын зардал |                                            | 20,831.9   | 19,227.6  | 92.3  | 30,088.3   | 26,543.4  | 88.2  |
| 2.1                               | Зээлийн хүүгийн зардал                     | 10,835.7   | 10,370.9  | 95.7  | 10,338.1   | 10,338.1  | 100.0 |
| 2.2                               | Зам засвар, үйл ажиллагааны зардал         | 9,996.2    | 8,856.7   | 88.6  | 19,750.2   | 16,205.3  | 82.1  |
| "Эрдэнэс Монгол" ХХК-ийн зардал   |                                            | 5,046.0    | 4,484.9   | 88.9  | 9,408.5    | 7,854.2   | 83.5  |
| 2.3                               | Цалин, шимтгэлийн зардал                   | 2,475.6    | 2,398.6   | 96.9  | 2,911.0    | 2,723.1   | 93.5  |
| 2.4                               | Оффисын түрээсийн зардал                   | 625.4      | 433.7     | 69.3  | 718.8      | 714.6     | 99.4  |
| 2.5                               | Гадаад албан томилолт                      | 266.5      | 270.3     | 101.4 | 486.2      | 424.7     | 87.3  |
| 2.6                               | Мэдээлэл, зар сурталчилгаа                 | 207.2      | 206.4     | 99.6  | 1,958.0    | 1,784.4   | 91.1  |
| 2.7                               | Гэрээт ажил                                | 217.0      | 203.0     | 93.5  | 300.0      | 336.1     | 112.0 |
| 2.8                               | ТУЗ-ийн зардал                             | 122.8      | 106.4     | 86.6  | 239.8      | 249.9     | 104.2 |
| 2.9                               | Бусад зардал                               | 1,131.4    | 866.5     | 76.6  | 2,794.7    | 1,621.3   | 58.0  |
| Нэмэлт зардал                     |                                            |            |           |       | 1,444.5    | 4,322.8   | 299.3 |
| 2.10                              | АХБ-ны төслийн дотоод санхүүжилтийн зардал |            |           |       | 1,444.5    | 4,322.8   | 299.3 |
| Хөрөнгө оруулалтын зардал         |                                            | 4,845.3    | 2,030.4   | 41.9  | 16,106.0   | 4,076.7   | 25.3  |
| 2.11                              | Үндсэн хөрөнгө                             | 1483.7     | 456.1     | 30.7  | 12,446.1   | 2,163.9   | 17.4  |
| 2.12                              | Төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалт      | 1708.1     | 622.7     | 36.5  | 645.0      | 4.4       | 0.7   |
| 2.13                              | Охин компанид оруулах хөрөнгө оруулалт     | 1653.5     | 951.6     | 57.6  | 3,014.8    | 1,908.5   | 63.3  |

1.32. Энэ нь тус компани Засгийн газрын 2006 оны 266 дугаар тогтоол, ТӨХ-ны 2007 оны 52 дугаар тогтоолоор компани байгуулагдсан үндсэн чиг үүргийн хүрээнд ажиллаагүй, компанийн дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-т заасан үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлээгүйтэй холбоотой байна.

1.33. Цаашид “Эрдэнэс Монгол” ХХК-ийн орлогын эх үүсвэрийг компанийн дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1<sup>3</sup>, 15.2<sup>4</sup>-т заасны дагуу зээл, хөрөнгө оруулалт, ногдол ашиг, хөрөнгийн өгөөж, хувьцаа борлуулсны орлого, менежментийн төлбөрөөр бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.


**Компанийн үйл ажиллагаанд хамааралгүй 1.6 тэрбум төгрөгийг зардлыг санхүүжүүлсэн байна**

1.34. ТУЗ-ийн тогтоолоор компанийн үйл ажиллагааны зардлыг 2016 онд нийт 30,723.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 23,712.5 сая төгрөгийг зарцуулсан, 2017 онд 57,047.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 42,797.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

<sup>3</sup> Компани нь зээл, хөрөнгө оруулалт, ногдол ашиг, хөрөнгийн өгөөж, хувьцаа борлуулсан орлогын эх үүсвэрээс санхүүжнэ

<sup>4</sup> Компани охин компанитайгаа менежментийн төлбөрийн гэрээ байгуулж, төлбөр авах бөгөөд төлбөрийн хэмжээг гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл батална

**Дүрслэл 1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны үйл ажиллагааны зардлын бүтэц /сая төгрөгөөр/**



Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан

1.35. Засгийн газрын шийдвэрийг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Монгол Улсын Үндэсний брэндийн зөвлөл<sup>5</sup>”-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг баталж, гүйцэтгэлээр 2017 онд компанийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагааг санхүүжүүлж, зориулалтын бус зардалд 1,598.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

1.36. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4.2-т “Хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох, хөрөнгө оруулах” гэж заасныг үндэслэн охин болон хараат компаниудад зээл олгож, 2017 оны жилийн эцсийн байдлаар зээл болон зээлийн хүүгийн нийт 9,674.6 сая төгрөгийн авлагыг үүсгэсэн байна.

**Хүснэгт 8. Охин болон хараат компаниас авах зээл болон зээлийн хүүгийн авлагын судалгаа**

/сая төгрөгөөр/

| Он   | Компанийн нэр              | Бүртгэсэн авлага           |                          |                |              | Нийт авлагын дүн |
|------|----------------------------|----------------------------|--------------------------|----------------|--------------|------------------|
|      |                            | Өмнөх оны зээлийн үлдэгдэл | Тайлант онд олгосон зээл | Зээлийн хүү    | Бусад        |                  |
| 2016 | "Эрдэнэс Шивээ Энэржи" ХХК | -                          | 363.0                    | 23.8           |              | 848.2            |
| 2017 | "Эрдэнэс Шивээ Энэржи" ХХК |                            | 326.2                    | 120.2          | 15.0         |                  |
| 2016 | "Эрдэнэс Метан" ХХК        | -                          | 228.0                    | 18.8           | 0.2          | 399.3            |
| 2017 | "Эрдэнэс Метан" ХХК        |                            | 94.5                     | 52.8           | 5.0          |                  |
| 2016 | "Эрдэнэс Оюутолгой" ХХК    | 3,543.0                    | 951.6                    | 348.5          | 35.0         | 6,308.3          |
| 2017 | "Эрдэнэс Оюутолгой" ХХК    |                            | 890.5                    | 499.7          | 40.0         |                  |
| 2016 | "Мон-Атом" ХХК             | 453.9                      | 155.1                    | 81.3           | 4.7          | 2,118.8          |
| 2017 | "Мон-Атом" ХХК             |                            | 1,181.0                  | 227.8          | 15.0         |                  |
|      | <b>Нийт дүн</b>            | <b>3,996.9</b>             | <b>4,189.9</b>           | <b>1,372.9</b> | <b>114.9</b> | <b>9,674.6</b>   |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016, 2017 оны санхүүгийн тайлан

1.37. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ” гэж заасныг үндэслэн “Мон-Атом” ХХК-ийн төрийн мэдлийн хувьцааг ЗГ албан ёсоор “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлээгүй байхад тус компанид 1,336.1 сая төгрөгийн зээл олгож, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4.2-т “Хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох, хөрөнгө оруулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.38. Охин болон хараат компаниуд үйл ажиллагаа тогтмолжоогүй, орлогын эх үүсвэргүйгээс шалтгаалан толгой компаниас дээр дурдсан нэр бүхий 4 компанид олгосон 4,189.9 сая төгрөгийн зээлийг төлж чадахгүйд хүрч зээл, зээлийн хүүгийн авлага хуримтлагдан нийт 9,674.6 сая төгрөгт хүрчээ.



1.39. Цаашид “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үйл ажиллагаа явуулаагүй болон үр ашиггүй ажиллаж байгаа бусад охин, хараат компаниудыг татан буулгах эсэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

### Худалдан авах ажиллагааны 90.6 хувь нь зам засвар болон боомтын үйл ажиллагаанд зарцуулж байна

1.40. “Эрдэнэс Монгол” ХХК 2016 онд 413.0 сая төгрөгийн, 2017 онд 13,009.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулжээ.

1.41. Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.1<sup>6</sup>, 2.7<sup>7</sup> дах заалтыг зөрчин компанийн 2016, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулаагүй, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захирал 4 удаа, ТУЗ-ийн 2017 оны 31 дүгээр тогтоолоор 1 удаа тодотгосон зөрчлүүд илэрлээ.

1.42. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016-2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн худалдан авах ажиллагааны зардлын 0.09 хувь нь компанийн дотоод ажил үйлчилгээнд, 90.6 хувь нь авто замын засвар арчлалт болон боомтын үйл ажиллагаанд, 0.002 хувийг “Монгол Улсын үндэсний брэндийн зөвлөл”-ийн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн нь тус компани үндсэн чиг үүргийн дагуу ажиллаж чадаагүй байна.

### Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн судалгаа

| № | Он   | Дотоод ажил үйлчилгээнд |         |      | Авто зам болон боомтын үйл ажиллагаанд |          |      | Үндэсний брэндийн зөвлөлийн үйл ажиллагаанд |      |       | Нийт дүн |
|---|------|-------------------------|---------|------|----------------------------------------|----------|------|---------------------------------------------|------|-------|----------|
|   |      | Тоо                     | Дүн     | Хувь | Тоо                                    | Дүн      | Хувь | Тоо                                         | Дүн  | Хувь  |          |
| 1 | 2016 | 9                       | 1,454.9 |      |                                        |          |      |                                             |      |       | 1,454.9  |
| 2 | 2017 | 12                      | 804.4   | 0.03 | 20                                     | 22,371.7 | 96.7 | 2                                           | 57.9 | 0.002 | 23,234.0 |
|   | Нийт | 21                      | 2,259.3 | 0.09 | 20                                     | 22,371.7 | 90.6 | 2                                           | 57.9 | 0.002 | 24,688.9 |

Эх сурвалж: 2016, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

1.43. Дотоод ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны төсөвт өртгийг тооцоо судалгаагүй хийсэн, гарах үр дүнг тооцоогүй, захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааг арвилан хэмнэлтгүй зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Албан хэрэгцээнд зориулж 48.0 сая төгрөгөөр 14 нэр төрлийн 70 гаруй бараа материал худалдан авахаар төлөвлөсөн боловч 47.6 сая төгрөгөөр 9 нэр төрлийн 34 ширхэг компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан нь төлөвлөлтийн үед хэрэгцээг тодорхойлоогүй, үнийн судалгаа хийгээгүйгээс батлагдсан төсөвт өртгөөр цөөн тооны бараа нийлүүлсэн;
- Албан тасалгааны тавилга худалдан авах 369.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Анун” ХХК 298.5 сая төгрөгийн үнийн санал ирүүлснээр шалгарч 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдөр гэрээ байгуулсан боловч 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээнд нэмэлт оруулж, үнийн дүнг 28.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- Азийн хөгжлийн банкны Компанийн засаглалыг чадавхжуулах төслийн хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компаниудын нээдлийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах ажлыг ОУ-ын зөвлөхөөр хийлгэхээр төлөвлөсөн боловч 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийн тендер зарлан тус ажлыг “Севиллиа Аудит” ХХК-тай гэрээ байгуулж, 46.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн;
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дотоод нөөцийг ашиглах боломжтой байхад эрх зүйн баримт бичгийг орчуулах үйлчилгээнд 49.5 сая төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргаж, худалдан авах ажиллагааг арвилан хэмнэх боломжийг алдсан.
- Цахим хуудас ажиллуулдаг, олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий мэргэжилтнүүд байхад компанийн үйл ажиллагаатай холбогдох мэдээ мэдээллийг түгээх 24.8 сая төгрөгийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлсэн боловч аудитын явцад гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн зарим сайтын мэдээлэлд хайлт хийж үзэхэд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаарх мэдээлэл гарч ирэхгүй байв.

1.44. Батлагдсан төсвийг төлөвлөлт муутай, арвилан хэмнэлтгүй зарцуулснаар хөрөнгө оруулалт үр ашиггүй болгох эрсдэл үүсэж байгаа тул худалдан авах ажиллагааг Төрийн болон

<sup>6</sup> Худалдан авалтын төлөвлөгөөг төсвийн төслийн хамт боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах

<sup>7</sup> Захиалагч төсвийн тодотгол хийхэд худалдан авах ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд тухайн жилийн явцад шинээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, түүнийг санхүүжүүлэх буюу шинээр төсөл, арга хэмжээ эхлүүлэх шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг тусгана.

орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн төлөвлөж, гүйцэтгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

1.45. “Эрдэнэ Монгол” ХХК-ийн 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй “Геологи, эрэл үнэлгээний ажил гүйцэтгэх” тендерийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар зарласан боловч үнийн санал ирүүлсэн компаниудаас татгалзаж, урилга хүргүүлээгүй, тендерт оролцоогүй, “Жеопро монголия инк” ХХК-тай гүйцэтгэх захирлын шийдвэргүйгээр 2016 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 38.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх ЭМГЛ-2016/07/22 дугаар гэрээг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Жеопро монголия инк” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Гантулга нар байгуулж, тус ажлыг гүйцэтгүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байна.

1.46. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бизнес төлөвлөгөөнд батлагдсан мэдээлэл, зар сурталчилгааны зардалд 2016 онд 207.2 сая, 2017 онд 229.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч тус ажлыг гүйцэтгүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4<sup>8</sup>, 8.5<sup>9</sup> дах заалтыг зөрчин сонгон шалгаруулалт явуулаагүй, нийт төсөвт өртгийг хувааж, 2016 онд 21 хуулийн этгээдтэй 196.5 сая төгрөг, 2017 онд 24 иргэн хуулийн этгээдтэй 110.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

1.47. Засгийн газрын 2013 оны 299 дүгээр тогтоолоор Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн авто замыг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлснээр тус авто замын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах үүрэг бүхий “Гашуун сухайт авто зам” ХХК-ийг 2014 онд байгуулж, гэрээгээр хамтран ажиллаж байна.

1.48. “Гашуун сухайт авто зам” ХХК-тай байгуулсан гэрээний 2 дугаар зүйлийн 2.4-т “Гүйцэтгэгч нь авто замын ашиглалт, засварын ажлыг гүйцэтгэх бөгөөд энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байх хугацаанд авто зам ашиглалт, засварын ажлыг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчин 2015-2016 онд 9.3 тэрбум төгрөгийн, 2018 онд 5.4 тэрбум төгрөгийн замын засвар арчлалтын ажлыг 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

**Хүснэгт 10. Замын засвар арчлалтад  
2015-2018 онд зарцуулсан хөрөнгийн судалгаа**  
/сая төгрөгөөр/

| Он              | Авто замын хураамжаас төвлөрүүлсэн орлого /үүнээс/ |               |                       |                |
|-----------------|----------------------------------------------------|---------------|-----------------------|----------------|
|                 | Замын засварт                                      | Хоолойн ажилд | Хөвөө, шуудууны ажилд | Эвдрэл         |
| 2015            | 4,135.9                                            | -             | -                     | -              |
| 2016            | 5,180.6                                            | 128.0         | -                     | -              |
| 2018            |                                                    | 487.6         | 561.2                 | 4,632.6        |
| <b>нийт дүн</b> | <b>9,316.5</b>                                     | <b>615.6</b>  | <b>561.2</b>          | <b>4,362.6</b> |

Эх сурвалж: ААН-үүдтэй байгуулсан гэрээнүүд

1.49. “Гашуун сухайт авто зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Болд 2016 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2<sup>10</sup> -т заасан шаардлагыг хангахгүй байхад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг үндэслэн зам засвар, арчлалтын ажлыг гүйцүүлэхээр “Үйлсийн зам” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

1.50. Зам засвар арчлалтын ажлын худалдан авах ажиллагааг 2017 оноос эхлэн “Эрдэнэс Монгол” ХХК зохион байгуулж, тендерт шалгарсан компаниар гүйцэтгүүлж<sup>11</sup>, 2017 онд нийт 21.7 тэрбум төгрөгийн 11 ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 12.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**Хүснэгт 11. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны судалгаа** /сая төгрөгөөр/

| № | 2017 оны худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл                                                            | Төсөвт өртөг | Гэрээний дүн |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|--------------|
| 1 | Гашуун сухайт Таван толгой чиглэлийн 239км авто замын өвөл, зуны замын арчлалт, тэмдэг тэмдэглэгээний ажил | 943.5        | 772.7        |

<sup>8</sup> Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

<sup>9</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

<sup>10</sup> 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд захиалагч байна

<sup>11</sup> замын ашиглалт, засвар арчлалтанд шаардагдах санхүүжилтийг замын хураамжаас санхүүжүүлнэ

|    |                                                                                                                                                      |                 |                 |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-----------------|
| 2  | Гашуун сухайт Таван толгой чиглэлийн 239км авто замын засварын, ажил                                                                                 | 10,505.3        | 9,249.6         |
| 3  | Зам засвар, арчлалтын хөндлөнгийн хяналтын ажил                                                                                                      | 99.0            | 98.6            |
| 4  | Автозамын техник ашиглалтын түвшний судалгааны ажил                                                                                                  | 62.2            | -               |
| 5  | Замын электрон самбарын иж бүрдэл суурилуулах                                                                                                        | 60.0            | 59.8            |
| 6  | Автозамын гадаргуун боловсруулалтын ажил                                                                                                             | 776.8           | -               |
| 7  | Таван Толгой -Гашуун сухайт чиглэлийн авто замд нүүрс тээвэрлэгч тээврийн хэрэгслүүдийг зогсоол барьж байгуулах                                      | 4,883.7         | -               |
| 8  | Шалган нэвтрүүлэх цэгийн өргөтгөл, ус зайлуулах хоолой, тээврийн хэрэгслийн амралтын болон түр зогсоолын зураг төсөл боловсруулах                    | 50.0            | 49.2            |
| 9  | Шалган нэвтрүүлэх цэг №1 болон №3 -ийн өргөтгөлийн ажил                                                                                              | 2,490.0         | 495.0           |
|    | Ус зайлуулах хоолой                                                                                                                                  |                 | -               |
|    | Тээврийн хэрэгслийн амралтын болон түр зогсоол барих ажил гүйцэтгэх                                                                                  |                 | 481.2           |
| 10 | Гашуун сухайт авто зам” ХХК-ийн ШНЦ-1 болон 3-ын эрчим хүчний хэрэглээг хангах 80 кВт-ын нарны цахилгаан станцын зураг төсөл, барилга угсралтын ажил | 841.2           | 754.5           |
| 11 | Автомашин худалдан авах тендер                                                                                                                       | 1,036.0         | 805.7           |
|    | <b>НИЙТ ДҮН</b>                                                                                                                                      | <b>21,747.7</b> | <b>12,057.1</b> |

Эх сурвалж: 2017 оны ХАА-ны төлөвлөгөө ААН-үүдтэй байгуулсан гэрээ

1.51. Аудитын явцад авто замд хийгдсэн урсгал засварын ажлыг шалгаж үзэхэд нийт 120 гаруй километр замд олон тооны нүх үүссэн, хучилт бүтцээрээ эвдэрсэн байгаа нь жил тус бүр хийсэн урсгал засварт зарцуулсан хөрөнгө үр ашиггүй болгож байна.

1.52. Авто замын их засварыг<sup>12</sup> 2019 онд хийхээр гэрээнд заасан боловч замын одоогийн нөхцөл, чанар байдалд техник ашиглалтын түвшнийг тогтоож мэргэжлийн дүгнэлт гаргуулах ажил хийгдээгүй, тус ажлыг 2017, 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд гүйцэтгэхээр тусган тендер зарласан боловч үнийн санал ирээгүй гэсэн шалтгаанаар цуцлагдсан байна.

1.53. Дээрх ажил хийгдээгүйгээс шалтгаалан авто замын их засварын ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртгийг тооцоолох боломжгүй болох эрсдэлтэй байна.

1.54. Авто зам засварын ажилд “Гашуун сухайт авто зам” ХХК-ийн орон тооны 2, гэрээт 3, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 1, нийт 6 авто замын инженер өдөр тутам хяналт тавьдаг, хөндлөнгийн хяналтын ажлыг 2017, 2018 онд Зам, тээврийн хөгжлийн төвөөр 200.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч замын нөхцөл байдалд нийцсэн бодитой дүгнэлт гаргаагүй байна.

1.55. Цаашид “Гашуун сухайт авто зам” ХХК-ийн зөвхөн автозамын орлого цуглуулдаг, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавьдаг үйл ажиллагааг өөрчилж, шуурхай бригадыг ажиллуулах замаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн тусгай зориулалтын замд тавигдах шаардлагын дагуу засвар, үйлчилгээг чанартай гүйцэтгүүлж, хөрөнгийг хэмнэж ажиллах шаардлагатай байна.

1.56. Нүүрсний үнийн өсөлттэй холбоотой Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1<sup>13</sup>, 29.4.1<sup>14</sup>-т заасныг үндэслэн Гашуун сухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Боомтын үндэсний зөвлөлийн дарга Б.Чойжилсүрэнгийн Гаалийн ерөнхий газар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагуудад өгсөн үүргийн дагуу 2017 онд компанийн хөрөнгөөр 375.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах, шинээр гүйцэтгэх арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжүүлсэн байна.

#### Хүснэгт 12. Худалдан авах болон хэрэгжүүлэх арга хэмжээний судалгаа /сая төгрөгөөр/

| № | ХАА-ны 2017 оны төлөвлөгөө                       | Тоо хэмжээ | Төсөвт өртөг |
|---|--------------------------------------------------|------------|--------------|
| 1 | Боомтын гадна талбайн гэрэлтүүлгийн цамхаг барих | 6          | 18.0         |
| 2 | Цамхагт суурилуулах лед гэрэл                    | 18         | 9.0          |
| 3 | Теле камерын хяналтын систем угсрах              | 20         | 60.0         |
| 4 | Богино долгионы станц                            | 120        | 26.0         |
| 5 | Нөөцийн дизель станц                             | 1          | 110.6        |
| 6 | Боомтын хашааг өргөтгөх                          | 1600 м     | 104.0        |
| 7 | Боомтын хуучин байрны засвар                     | 4          | 48.0         |
|   | <b>НИЙТ ДҮН</b>                                  |            | <b>375.6</b> |

<sup>12</sup> Ашиглалт, үйлчилгээ, засвар арчлалт гүйцэтгэх гэрээний 6 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт

<sup>13</sup> Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бүс хилийн боомтын үндэсний зөвлөл ажиллана.

<sup>14</sup> хилийн боомтыг байгуулах, өргөтгөх, боомтын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулах;

1.57. ТУЗ-ийн 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Гаалийн ерөнхий газрын 87.0 сая төгрөгөөр тооцож ирүүлсэн 3 арга хэмжээг 279.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан боловч зарласан тендерүүд дараах шалтгаанаар хүчингүй болсон байна. Тухайлбал:

- Теле камерын хяналтын систем угсрах ажлын тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1<sup>15</sup>-д зааснаар барааны тендер байх ёстой боловч ажил гүйцэтгэх тендерээр зарлагдаж, тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1<sup>16</sup>-д заасны дагуу цуцлагдсан,
- Гэрэлтүүлгийн цамхаг барьж гэрэл суурилуулах ажлын тендерт шаардлага хангаасан компани оролцоогүй гэсэн шалтгаанаар хойшлогдож 2018 онд төлөвлөсөн ч зарлагдаагүй, зарим ажлуудыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.58. 2017 онд гаалийн улсын байцаагч нарын болон боомтын ажилчдын байрны цахилгааны угсралт, дотор талын тавилга, компьютер тоног төхөөрөмж, эд хөрөнгийг нийлүүлэх 179.3 сая төгрөгийн төсөв өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан 3 гүйцэтгэгчтэй 166.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч зарим ажлууд дутуу хэрэгжсэн, тендерийн шаардлага хангаагүй хуучин тоног төхөөрөмж нийлүүлсэн, ашиглагч талд хүлээлгэн өгөөгүй, гэрээг дүгнээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Гаалийн улсын байцаагч нарын зөөврийн байрны дотор цахилгаан монтаж, цахилгаан шугам сүлжээ угсрах ажил гадна талаасаа цахилгааны эх үүсвэртэй холбогдоогүй;
- Боомтын ажилчдын байранд шаардлагатай хэдэн нэр төрлийн хэдэн ширхэг ямар эд хөрөнгө худалдан авсан нь тодорхой бус, хуучин компьютер нийлүүлсэн;
- Тендер шалгаруулалтаар нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээг гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй, ашиглалтад оруулаагүй байна.

1.59. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, 49 дүгээр зүйлийн 49.1-т “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2.10-т “гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### Охин компаниудын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна

1.60. “Багануур” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 02 дугаар сарын 16-ны 08 дугаар тогтоолоор 72,661.4 сая төгрөгийн 107, 2017 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор нийт 75,162.5 сая төгрөгийн 108 бараа, ажил, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг баталсан байна.

#### Хүснэгт 13. “Багануур” ХК-ийн 2016-2017 оны ХАА-ны төлөвлөгөө /сая төгрөгөөр/

| он   | нээлттэй тендерээр |            | харьцуулалтаар |            | шууд гэрээгээр |            | нийт дүн |            |
|------|--------------------|------------|----------------|------------|----------------|------------|----------|------------|
|      | тоо                | мөнгөн дүн | тоо            | мөнгөн дүн | тоо            | мөнгөн дүн | тоо      | мөнгөн дүн |
| 2016 |                    | 40,955.9   |                | 418.7      |                | 31,286.8   | 0        | 72,661.4   |
| 2017 | 35                 | 42,844.7   | 16             | 416.7      | 72             | 38,431.1   | 123      | 81,692.5   |

Эх сурвалж: Багануур ХХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

1.61. “Багануур” ХК-ийн 2016-2017 оны худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Багануур” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоолыг үндэслэн 15 нэр төрлийн 6,530.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэгч болон гэрээт борлуулагчаас шууд гэрээгээр худалдан авсан;
- 2016 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4<sup>17</sup>, 8.5<sup>18</sup> дахь заалтыг зөрчин Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго

<sup>15</sup> “ажил” гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг. Бараа нийлүүлэлтийн үнэ нь ажлын үнээс их байвал тухайн гэрээг “барааны гэрээ” гэж тооцно;

<sup>16</sup> энэ хуулийг зөрчсөн захиалагчийн үйлдэл буюу шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөх;

<sup>17</sup> Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

<sup>18</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.



үнээс дээш байхад 2,316.82 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

- 2016 онд нийт 40 нээлттэй тендер зарлахаас 35 тендерийг зохион байгуулж, гэрээ байгуулснаар тайлагнасан боловч үнэлгээний хорооны тушаал, хуралдааны тэмдэглэл, тендерийг зарласан зар, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмж, гэрээ дүгнэсэн акт зэрэг тендерийн бичиг баримтыг архивын нэгж үүсгэж үдэж цэгцлээгүй байгаа тул аудитын явцад тухайн тендерийг зарласан болон зохион байгуулсан эсэхийг нотлох боломжгүй байлаа. Энэ нь тухайн үнэлгээний хороонд ажилласан албан тушаалтнууд Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийг зөрчсөн байна. Мөн захиалагч дээрх журмын 1.3 дахь заалтыг үндэслэн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.
- Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн дагуу гаргаагүй, зарим нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг 2016 онд 7,515.2 сая төгрөгөөр, 931.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн худалдан авсан байна.

1.62. “Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 03 дугаар сарын 04-ны 06 дугаар тогтоолоор 37,609.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувьцааны орлого тодорхойлогдсоны дараа худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж баталсан боловч хувьцааны орлого тодорхойлогдоогүй, ТУЗ зөвшөөрөл өгөөгүй байхад 20,888.2 сая төгрөгийн дараах тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. Үүнд:

- “Ооками” ХХК-аас 156.0 сая төгрөгийн өндөр даралтын хийн компрессор;
- “Экологбус” ХХК-аас 116.8 сая төгрөгийн энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх тоног төхөөрөмж;
- “Тэнүүн хас сар” ХХК 53.3 сая төгрөгийн тэсэлгээний алсын зайны удирдлага;
- “Юнайтед белаз машинери” ХХК-аас 15,278.1 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулан хөрсний 130 тоннын автосамосвал;
- Транс Техно Маркет ХХК-аас 1,980.0 ам.долларын зээлийн гэрээ байгуулан 3,981.2 сая төгрөгийн 10-15мЗ-ийн цахилгаан экскаватор;
- Нисээч Интернэшнл ХХК-аас 136.9 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулан /3,2 мЗ/ дугуйт ачигч;
- “Юнайтедпартс” ХХК-аас 105.1 сая төгрөгийн /9мЗ/ түлш цэнэглэгч машин;
- “Хөх өндөр уул” ХХК-аас 258.9 сая төгрөгийн хаалттай хуваарилах байгууламж;
- “Гантесла” ХХК-аас гэрээ байгуулахгүйгээр 15.2 сая төгрөгийн 110/6 кв-ын дэд станцын конденсаторын байгууламж;
- “Тех Индустрия” ХХК-аас 748.9 сая төгрөгийн генератор ГПЭ2500-750 УХЛЗ ТУ16-514240-78, Двигатель МПЭ-1120-630УЗ;
- Гэрээ байгуулаагүй 10.0 сая төгрөгийн оффисын барилгын доторлогооны материал, 27.8 сая төгрөгийн нарядны ширээ, сандал, хувцасны шкаф.

1.63. “Шивээ-Овоо” ХК-ийн 2016 оны худалдан авалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн тогтоолоор батлахаас өмнө Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тушаал гаргаж 60 тендерийг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулсан нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8<sup>19</sup>-д заасныг зөрчин эрх олгоогүй байхад төсвийг захиран зарцуулах үйлдэл гаргасан байна.

1.64. Хувьцааны орлого тодорхойлогдсоны дараа 36 нээлттэй тендер шалгаруулахаар төлөвлөсөн боловч хувьцааны орлого тодорхойлогдоогүй, санхүүжүүлэх төсөв тодорхойгүй, баталгаагүй төсвийг үндэслэл болгон Гүйцэтгэх захирал О.Отгонбаатарын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн тушаалаар 26 тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь 19,395.5 сая төгрөгийн өр төлбөрийг үүсгэн компанийг санхүүгийн эрсдэлд оруулах нөхцөлийг бий болгосон байна.

1.65. ТУЗ-ийн баталсан 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5 тендерийг гүйцэтгэх захирал О.Отгонбаатар шууд нэмж, дахин төлөвлөгөө гаргасан нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь заалтыг зөрчсөн байна.

1.66. 2016 онд нийт 65 нээлттэй тендер зохион байгуулахаар төлөвлөснөөс 35 тендерийг зохион байгуулж гэрээ байгуулсан боловч аудитын явцад 23 тендерийн бичиг баримтыг үдэж архивлагдсан, 12 тендерийн баримтууд архивлагдаагүй байгаа нь тухайн тендерийг зарласан эсэх, бодитой зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй байна.

1.67. Энэ нь үнэлгээний хороонд ажилласан албан тушаалтнууд Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийг зөрчсөн, “Шивээ-Овоо” ХК-ийн удирдлагууд тус журмын 1 дүгээр зүйлийн 1.3-т заасны дагуу үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.

<sup>19</sup>Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.



1.68. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэн уурхайн үйл ажиллагааны онцлогийг харгалзан батлуулж хэвшээгүй, худалдан авах ажиллагааны тайлагналыг хуулийн дагуу гаргаагүй байна.

1.69. “Шивээ-Овоо” ХК 2017 онд нийт 32,975.7 сая төгрөгийн 149 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 32,686.0 сая төгрөгийн 278 бараа, ажил, үйлчилгээг худалдан авчээ.

1.70. “Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 9,291.4 сая төгрөгийн 18 арга хэмжээ төлөвлөснийг үндэслэн гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-ын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/63 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулж, нийт 4,840.0 сая төгрөгийн 5 арга хэмжээний худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

1.71. “Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар 2017 онд Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8<sup>20</sup> дахь заалтыг зөрчиж ТУЗ-ийн тогтоол гараагүй, эрх олгоогүй байхад хөрөнгийг захиран зарцуулах үйлдэл гаргаж, худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

- 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлж, батлуулаагүй, 2017 онд нээлттэй тендер шалгаруулалтаар 15,923.8 сая төгрөгийн 33, шууд гэрээгээр 7,291.0 сая төгрөгийн 227, нийт 23,394.6 сая төгрөгийн 260 бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна.
- Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-ын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/10 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулахаас өмнө нийт 22 гэрээ байгуулж, 1,377.5 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн.

1.72. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын үе шат бүрд хууль зөрчигдөж, тендерийн үнэлгээний хороо хуралдаагүй, хурлын тэмдэглэл хөтлөөгүй, сонгон шалгаруулалтын аргыг оновчтой сонгоогүй, сонгон шалгаруулалтад ирсэн саналуудыг журмын дагуу үнэлээгүй, харьцуулалт хийхгүйгээр шууд гэрээ байгуулсан, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлээгүй байна.

1.73. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бизнес төлөвлөгөөнд өөрийн болон охин компаниудын худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, тус бодлогод үндэслэн худалдан авах ажиллагааг оновчтой, үр ашигтай зохион байгуулах удирдлагын тогтолцоог бий болгохоор тусгасан боловч тус ажил хэрэгжээгүйгээс худалдан авах ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах ажил хяналтгүй, хууль, журмын дагуу явагдаагүй байна.

1.74. Төрийн аудитын байгууллагаас “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн худалдан авах ажиллагаанд эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

1.75. Цаашид толгой болон охин компаниудын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил үйлчилгээ, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах худалдан авалтын нэгдсэн тогтолцоог бий болгох, хуульд нийцүүлэн холбогдох журмыг боловсруулан мөрдөх, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

***Зарим охин болон хараат компаниудын санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй байна***

1.76. Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Ийнхүү гүйцэтгэсэн аудитын тайлангийн чанарыг төрийн аудитын байгууллага баталгаажуулна” гэж заасныг үндэслэн ҮАГ 2016 онд “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК, “Мон-Атом” ХХК-

---

<sup>20</sup> Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэрэгээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

иудын 2016 оны санхүүгийн тайланд хийх хараат бус аудитын компаниудыг шууд гэрээгээр сонгон шалгаруулж, аудитын тайланг баталгаажуулсан байна.

1.77. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/178 дугаар тушаалаар “Үндэсний аудитын газраас гэрээгээр 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах” Үнэлгээний хороо байгуулагдаж, сонгон шалгаруулалт явуулснаар “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХК, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК, “Мон-Атом” ХХК-иудын 2017 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын компаниудыг сонгон шалгаруулж, аудитын тайланг баталгаажуулсан байна.

**Хүснэгт 14. ҮАГ-аас “Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компаниудын санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын судалгаа**

| № | Компанийн нэр                 | Байгуул сан огноо | 2016 оны санхүүгийн тайланд аудит хийсэн |                              | 2017 оны санхүүгийн тайланд аудит хийсэн эсэх |                              |
|---|-------------------------------|-------------------|------------------------------------------|------------------------------|-----------------------------------------------|------------------------------|
|   |                               |                   | Аудитын компанийн нэр                    | ҮАГ-аас баталгаажуулсан эсэх | Аудитын компанийн нэр                         | ҮАГ-аас баталгаажуулсан эсэх |
| 1 | "Эрдэнэс Монгол" ХХК          | 2006              | "Од бүртгэл Аудит" ХХК                   | Баталгаажсан                 | "Эйч Эл Би Монголиа Аудит" ХХК                | Баталгаажсан                 |
| 2 | "Эрдэнэс таван толгой" ХК     | 2010              | "БДО-Аудит" ХХК                          | Баталгаажсан                 | "Конфиденс Аудит" ХХК                         | Баталгаажсан                 |
| 3 | "Эрдэнэс Оюу Толгой" ХХК      | 2011              |                                          |                              | "Эйч Эл Би Монголиа Аудит" ХХК                | Баталгаажсан                 |
| 4 | "Эрдэнэс Метан" ХХК           | 2016              |                                          |                              | "Эйч Эл Би Монголиа Аудит" ХХК                | Баталгаажсан                 |
| 5 | "Эрдэнэс Ассет Менежмент" ХХК | 2016              |                                          |                              | "Эйч Эл Би Монголиа Аудит" ХХК                | Баталгаажсан                 |
| 6 | "Багануур" ХК                 | 2013              | "Сүлд-Аудит" ХХК                         | Баталгаажсан                 | "Сүлд-Аудит" ХХК                              | Баталгаажсан                 |
| 7 | "Шивээ-Овоо" ХК               |                   | "Есөнхангай Аудит" ХХК                   | Баталгаажсан                 | "Пантер Мидланд Аудит" ХХК                    | Баталгаажсан                 |
| 8 | "Мон-Атом" ХХК                | 2009              | "Од бүртгэл Аудит" ХХК                   | Баталгаажсан                 | "Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит" ХХК             | Баталгаажсан                 |

**Хүснэгт 15. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниудын санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, аудит хийгдээгүй компаниудын судалгаа**

| № | Компанийн нэр                 | Байгуул сан огноо | 2016 оны санхүүгийн тайланд аудит хийсэн    |                              | 2017 оны санхүүгийн тайланд аудит хийсэн эсэх |                              |
|---|-------------------------------|-------------------|---------------------------------------------|------------------------------|-----------------------------------------------|------------------------------|
|   |                               |                   | Аудитын компанийн нэр                       | ҮАГ-аас баталгаажуулсан эсэх | Аудитын компанийн нэр                         | ҮАГ-аас баталгаажуулсан эсэх |
| 1 | "Эрдэнэс Оюу Толгой" ХХК      | 2011              | "И.ЭС.ЭС.ЭС Аудит" ХХК                      | Баталгаажуулаагүй            |                                               |                              |
| 2 | "Эрдэнэс Метан" ХХК           | 2016              | Аудит хийгээгүй                             |                              |                                               |                              |
| 3 | "Эрдэнэс Ассет Менежмент" ХХК | 2016              | Аудит хийгээгүй                             |                              |                                               |                              |
| 4 | "Эрдэнэс Шивээ Энержи" ХХК    | 2016              | "Энич аудит" ХХК                            | Баталгаажуулаагүй            | Аудит хийгээгүй                               |                              |
| 5 | "Эрдэнэс Стийл" ХХК           | 2017              | 2017 онд байгуулагдсан учир аудит хийгээгүй |                              | "ЗЦН-Аудит" ХХК                               | Баталгаажуулаагүй            |
| 6 | "Эрдэнэс Ашид" ХХК            | 2017              | 2017 онд байгуулагдсан учир аудит хийгээгүй |                              | Аудит хийгээгүй                               |                              |

1.78. Дээрх хүснэгтээс харахад 2016 оны “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК-ийн санхүүгийн тайлангууд, 2017 оны “Эрдэнэс Стийл” ХХК-ны санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Эрдэнэс Ашид” ХХК-иудын 2016-2017 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

1.79. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зарим охин болон хараат компаниуд санхүүгийн тайлангаа төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, зарим компаниуд аудит хийлгээгүй байгаа нь толгой компанид санхүүгийн нэгдсэн бодлого байхгүй, гүйцэтгэх удирдлага өөрийн охин,

хараат компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

**ТУЗ-ийн тогтоолоор толгой болон охин, хараат компаниудын 2016 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар дахин аудит хийлгэсэн боловч аудитын дүгнэлт гараагүй байна**

1.80. “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компаниуд 2014-2016 онуудад “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар аудит хийлгэсэн бөгөөд тайлант онуудад нийт 960.0 сая төгрөг /НӨАТ ороогүй дүн/-ийг “Эрдэнэс Монгол” ХХК тус компанид төлсөн байна.

**Хүснэгт 16. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин болон хараат компаниудын санхүүгийн тайлант төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй, аудит хийгдээгүй компаниудын судалгаа**

| № | Компанийн нэр              | Аудитын үйлчилгээний болон нягтлах үйлчилгээний төлбөр /2014 он/ | Аудитын үйлчилгээний төлбөр /2015 он/ | Аудитын үйлчилгээний төлбөр /2016 он/ | Нийт дүн     |
|---|----------------------------|------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------|--------------|
| 1 | "Эрдэнэс Монгол" ХХК       | 80.0                                                             | 70.0                                  | 80.0                                  | 230.0        |
| 2 | "Эрдэнэс таван толгой" ХХК | 160.0                                                            | 185.0                                 | 80.0                                  | 425.0        |
| 3 | "Эрдэнэс Оюу Толгой" ХХК   | 40.0                                                             | 35.0                                  | 40.0                                  | 115.0        |
| 4 | "Багануур" ХК              | 25.0                                                             | -                                     | 40.0                                  | 65.0         |
| 5 | "Шивээ-Овоо" ХК            | 25.0                                                             | 30.0                                  | 35.0                                  | 90.0         |
| 6 | "Эрдэнэс Шивээ Энержи" ХХК | -                                                                | -                                     | 15.0                                  | 15.0         |
| 7 | "Эрдэнэс метан" ХХК        | -                                                                | -                                     | 5.0                                   | 5.0          |
| 8 | "Мон-Атом" ХХК             | -                                                                | -                                     | 15.0                                  | 15.0         |
|   | <b>Нийт дүн</b>            | <b>330.0</b>                                                     | <b>320.0</b>                          | <b>310.0</b>                          | <b>960.0</b> |

1.81. Дээрх хүснэгтээс 2016 оны “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин, хараат компаниудад хийсэн “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ны санхүүгийн тайлангуудад хийсэн аудитын дүгнэлтийг авч үзвэл доорх байдалтай байна.

**Хүснэгт 17. Толгой болон охин хараат компаниудын 2016 оны санхүүгийн аудитын дүгнэлтийн судалгаа** /сая төгрөгөөр/

| № | Компанийн нэр                                  | Аудитын төлбөр | Аудитын дүгнэлт | Аудитын дүгнэлт баталгаажсан эсэх         |
|---|------------------------------------------------|----------------|-----------------|-------------------------------------------|
| 1 | "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компани | 80.0           | Хязгаарлалттай  | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
|   | "Эрдэнэс Монгол" ХХК                           |                |                 |                                           |
| 2 | "Эрдэнэс таван толгой" ХХК                     | 80.0           | Хязгаарлалттай  | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
| 3 | "Эрдэнэс Оюу Толгой" ХХК                       | 40.0           | Зөрчилгүй       | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гарсан.   |
| 4 | "Багануур" ХК                                  | 40.0           |                 | Залруулга бичилтийг хүлээн зөвшөөрөөгүй.  |
| 5 | "Шивээ-Овоо" ХК                                | 35.0           | Хязгаарлалттай  | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
| 6 | "Эрдэнэс Шивээ Энержи" ХХК                     | 15.0           | Зөрчилгүй       | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
| 7 | "Эрдэнэс метан" ХХК                            | 5.0            | Зөрчилгүй       | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
| 8 | "Мон-Атом" ХХК                                 | 15.0           | Зөрчилгүй       | Баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй. |
|   | <b>Нийт дүн</b>                                | <b>310.0</b>   |                 |                                           |

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компаниудын 2016 оны санхүүгийн аудитын дүгнэлтүүд

1.82. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК толгой болон охин компаниудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийсэн боловч “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас бусад компаниудын аудитын дүгнэлтийг албан ёсоор баталгаажуулаагүй, компанийн ТУЗ-өөр хэлэлцүүлж, батлуулаагүй нь дээрх хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

1.83. “Эрдэнэс Монгол” ХХК Төрийн аудитын тухай хуулийн дагуу Хараат бус аудитын компаниар аудит хийлгэж байгаа бөгөөд “Эрнст энд Янг Аудит” ХХК-иар дахин аудит хийлгэсэн нь үйл ажиллагааны зардлыг өсгөж, нэгдсэн санхүүгийн тайлан гаргахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахад тус тусдаа аудит хийгдсэн санхүүгийн тайлангууд олон улсын стандартын шаардлагыг хангахгүй байна.

**Компанийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаагүй, ил тод мэдээлээгүй байна**

1.84. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Охин компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах ба толгой компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана”, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Компани охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана” гэж заасан боловч “Эрдэнэс Монгол” ХХК “Эрнст энд Янг Аудит” ХХК-иар 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргуулсан байна.

1.85. Энэ нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4-т “Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасантай зөрчилдөж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах боломжгүй болгох эрсдэлийг бий болгосон байна.

1.86. Мөн компанийн Гүйцэтгэх удирдлагын ажлын хариуцлагагүйгээс “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин, хараат компаниудын 2016-2017 оны аудит хийсэн санхүүгийн тайланг ТУЗ-өөр хянан баталгаажуулаагүй, Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1<sup>21</sup> дэх заалтыг зөрчин хувьцаа эзэмшигчид албан ёсоор танилцуулаагүй байна.

**Эдийн засгийн 2007-2017 оны үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийсэн боловч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шийдвэр гаргаагүй байна**

1.87. Сангийн Сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2007-2017 оны санхүүгийн мэдээлэлд тулгуурлан цэвэр орлого болон цэвэр ашгийн өсөлтийн түвшин, өөрийн хөрөнгийн өгөөж, үйл ажиллагааны харьцаа, өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцааны үзүүлэлтээр шинжилгээ хийсэн боловч компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага түүнийг хэлэлцээгүй, санхүү, эдийн засгийн өнөөгийн түвшин, ирээдүйн хандлагыг тодорхойлсон шийдвэр гараагүй байна.

---

<sup>21</sup> Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Компани нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна”

## Бүлэг 2. “Эрдэнэс Монгол” ХХК төрийг төлөөлөх засаглалыг үр нөлөөтэй удирдаж чадаагүйгээс төлөвлөсөн ажлууд үр дүнд хүрээгүй байна

### Охин болон хараат компаниудыг хөгжүүлэх бодлого бүрэн тодорхойлогдоогүйгээс бизнес төлөвлөлтийн уялдааг хангах тогтолцоо бүрдээгүй байна

2.1. “Эрдэнэс Монгол” ХХК өөрийн болон охин, хараат компанийн зорилго, зорилтыг нэгтгэн төрийн төлөөллийг хэрэгжүүлэн төрийн мэдлийн хувьцааны ногдол ашгийг төвлөрүүлэх үндсэн чиг үүрэгтэй боловч одоогийн байдлаар тэдний урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт нэгтгэгдээгүй, нэгдсэн бодлого, төлөвлөгөө байхгүй байна.

#### Хүснэгт 18. Охин болон хараат компаниудын зорилго, зорилтын судалгаа

| №  | Компаниуд                     | Компанийн зорилго                                                                                                                                                                                                      | Урт хугацааны зорилго                       |
|----|-------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|
| 1  | “Эрдэнэс Оюу Толгой” ХХК      | Оюу Толгой ХХК-ийн 34 хувийг эзэмшиж хяналт тавих                                                                                                                                                                      | Ногдол ашиг төвлөрүүлэх талаар тусгагдаагүй |
| 2  | “Багануур” ХК                 | Төвийн эрчим хүчний системийг нүүрсээр хангах                                                                                                                                                                          |                                             |
| 3  | “Шивээ Овоо” ХК               | Төвийн эрчим хүчний системийг нүүрсээр хангах                                                                                                                                                                          |                                             |
| 4  | “Эрдэнэс таван толгой” ХК     | Таван толгойн нүүрсний ордыг ашиглах, олборлох, дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулах                                                                                                                               |                                             |
| 5  | “Таван толгой түлш” ХХК       | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр                                                                                                                                                                                     |                                             |
| 6  | “Мон Атом” ХХК                | Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх |                                             |
| 7  | “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК    | “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК нь эрчим хүчний үйлдвэрлэлийн иж бүрэн цогцолборыг хүрэн нүүрсээр хангах эрчим хүчний нүүрсний нөөцийг бүрдүүлэх                                                                            |                                             |
| 8  | “Эрдэнэс Метан” ХХК           | Таван толгойн ордын нүүрсний давхаргын метан хийг олборлох, ашиглах                                                                                                                                                    |                                             |
| 9  | “Эрдэнэс стийл” ХХК           | Жилд 500,000 тонн металлургийн кокс, 300,000 тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх Кокс, ган төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулах                                                                                      |                                             |
| 10 | “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК | Хөрөнгийн удирдлага                                                                                                                                                                                                    |                                             |
| 11 | “Эрдэнэс Ашид” ХХК            | Ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт                                                                                                                                                                                |                                             |
| 12 | “Эрдэнэс Алт Ресурс” ХХК      | Алт цэвэршүүлэх, олборлох                                                                                                                                                                                              |                                             |

2.2. Толгой компани болон охин, хараат компанийн бизнес төлөвлөгөөний зорилго, зорилт нэгтгэгдээгүй, хоорондын үйл ажиллагааны уялдаа хангагдаагүй байгаа нь компани үндсэн зорилгодоо хүрэх боломжийг удаашруулж, үр ашиггүй ажиллах нөхцөлийг бий болгосон байна.

2.3. Охин болон хараат компанийн хувьцааны тодорхой хувийг хувийн компани эзэмшсэн тохиолдолд бие даасан ТУЗ-тэй, төр 100 хувь эзэмшсэн тохиолдолд бие даасан ТУЗ-гүй байхаар зохион байгуулалтын бүтэцтэй байна.

2.4. Одоогийн байдлаар бие даасан ТУЗ-тэй 5 охин, хараат компаниас “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК нь үйл ажиллагаа явуулдаг, харин “Эрдэнэс стийл” ХХК, “Эрдэнэс ашид” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

2.5. Бие даасан ТУЗ-тэй охин болон хараат компаниудын хувьд дараах дүрмийн заалтууд толгой компанийн дүрмийн заалттай давхардаж байна.


#### Хүснэгт 19. Толгой болон ТУЗ-тэй охин болон хараат компаниудын дүрмийн давхардсан заалтын судалгаа

| Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн заалт                                                                                                                                                                               | Охин болон хараат компанийн дүрмийн заалт                                                                                                                                                                                                         |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.1 “компани болон охин компанийн стратегийн зорилго, зорилт, хөрөнгө оруулалтын бодлого, богино, дунд болон урт хугацааны бизнес төлөвлөгөө, төсвийг батлах” | “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 “Компанийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах”                                                                                                                            |
|                                                                                                                                                                                                                    | “Багануур” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.2 “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах”                                                                |
|                                                                                                                                                                                                                    | “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5.9 “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэхийг ТУЗ-ийн хурлаар батлах” |



2.6. Толгой болон охин компаниудын дүрэмд охин компаниуд бизнес төлөвлөгөөг боловсруулж өөрийн болон толгой компанийн ТУЗ-өөр давхар батлуулахаар заасан боловч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ тэдгээрийн бизнес төлөвлөгөөг батлаагүй, “Охин болон хараат компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг үндэслэн удирдамж, чиглэл өгч ажилласан байна.

**Зураг 1. ТУЗ-тэй охин болон хараат компанийн толгой компанитай харилцах харилцаа**



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2.7. Дээрх зургаас харахад толгой болон охин, хараат компанийн захирлууд болон ижил чиг үүрэгтэй газар, хэлтсийн үйл ажиллагаа давхардаж, толгой компаниас тэднийг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа шат дамжлага ихтэйгээс шийдвэр гаргах ажил удаашрах нөхцөлийг үүсгэж байна.

2.8. Төвийн эрчим хүчний системд нүүрс нийлүүлдэг “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК-ийн 1 тонн нүүрсний үнийг Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14<sup>22</sup>-т заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хороо хянадаг бөгөөд эрчим хүчний нүүрсний үнийг тогтоох аргачлалын дагуу уурхайн зардлыг хянаж баталдаг байна.

2.9. Эрчим хүчний зохицуулах хорооны хянасан нийт зардлыг толгой болон охин компаниуд бизнес төлөвлөгөөндөө зөрүүтэй тусгасан нь уялдаа холбоогүй төлөвлөж байгааг харуулж байна.

**Хүснэгт 20. Бизнес төлөвлөгөөний орлого, зардлын судалгаа /сая төгрөгөөр/**

| Компанийн нэр                      |               |        | Багануур ХК |           |           | Шивээ-Овоо ХК |          |           |
|------------------------------------|---------------|--------|-------------|-----------|-----------|---------------|----------|-----------|
| Он                                 |               |        | 2016        | 2017      | 2018      | 2016          | 2017     | 2018      |
| Толгой компанийн бизнес төлөвлөгөө | Нийт зардал   | 1      | 117,819.0   | 111,592.9 | 139,100.0 |               | 45,090.0 | 49,900.0  |
|                                    | Нийт орлого   | 2      | 109,337.9   | 114,886.6 | 135,200.0 |               | 47,790.0 | 49,900.0  |
|                                    | Ашиг/Алдагдал | 3      | (8,481.1)   | 2,920.2   | (3,900.0) |               | 2,429.0  | -         |
| Бизнес төлөвлөгөө                  | Нийт зардал   | 4      | 116,275.9   | 112,627.7 | 135,904.9 | 46,700.5      | 47,965.9 | 49,888.3  |
|                                    | Нийт орлого   | 5      | 108,614.4   | 114,886.5 | 136,943.9 | 45,540.8      | 47,969.4 | 49,893.0  |
|                                    | Ашиг/Алдагдал | 6      | (7,666.6)   | 2,258.8   | 935.2     | (1,159.7)     | 3.41     | 4.72      |
| ЭХЗХ-ны хянасан санал              | Нийт зардал   | 7      | 102,367.9   | 111,472.2 | 134,019.1 | 46,894.8      | 42,592.2 | 52,834.9  |
|                                    | Нийт орлого   | 8      | 105,374.7   | 110,077.7 | 135,604.5 | 46,907.8      | 42,203.4 | 52,073.5  |
|                                    | Ашиг/Алдагдал | 9      | 3,006.8     | (1,394.4) | 1,585.3   | 13.0          | (388.8)  | (761.4)   |
| зөрүү                              | Нийт зардал   | 10=4-7 | 13,907.9    | 1,155.5   | 1,885.8   | (194.3)       | 5,373.8  | (2,946.5) |
|                                    | Нийт орлого   | 11=5-8 | 3,239.71    | 4,808.8   | 1,339.5   | (1,367.0)     | 5,766.0  | (2,180.4) |
|                                    | Ашиг/Алдагдал | 12=6-9 | (10,673.4)  | 3,653.2   | (650.1)   | (1,172.7)     | 2.10     | 766.12    |

2.10. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн өөрийн хөрөнгийн оролцоо хангалтгүй, урт болон богино хугацаат зээлээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас нийт хөрөнгөд эзлэх өр төлбөр “Багануур” ХК-ийн хувьд 72 хувь, “Шивээ-Овоо” ХК-ийн хувьд 94 хувь болж, төлбөр


<sup>22</sup> Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах;

барагдуулах чадвар адилхан 2 хувь, үйл ажиллагааны зардал төлөгдсөний дараах ашгийн эзлэх хувь “Багануур” ХК-д 7.6, “Шивээ-Овоо” ХК-д 14.5 бөгөөд хүчин чадлын хувьд “Багануур” ХК нь “Шивээ-Овоо” ХК-аас 2 дахин их боловч 1 төгрөгт ногдох цэвэр ашиг 2 компанид адил 0.002 төгрөг болсон нь санхүүгийн тогтвортой байдал алдагдаж, компани дампуурах эрсдэлийг бий болгож байна.

2.11. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн ашигт ажиллагаа хангалтгүй байгаа ч иргэдэд бага өртгөөр эрчим хүч нийлүүлэх боломжийг бүрдүүлж буй стратегийн ач холбогдолтой орд бөгөөд бие даасан ТУЗ-тэй компанийн хувьд “Эрдэнэс Монгол” ХХК-аас хамаарах бизнес төлөвлөлт, удирдлагын уялдааг хангах тогтолцоо бүрдээгүй байна.

2.12. Бие даасан ТУЗ-гүй охин, хараат компаниудын хувьд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-д бүрэн харьяалагддаг тул шийдвэр гаргах ажиллагаа харьцангуй хурдан боловч толгой компанийн удирдлага солигдоход гүйцэтгэх захирал өөрчлөгдөх сул талтай байна.


**Зураг 2. ТУЗ-гүй охин болон хараат компанийн толгой компанитай харилцах харилцаа**



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2.13. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бизнес төлөвлөгөөнд тусгасан ажлаас “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК болон “Гашуун сухайт автозам” ХХК-ийн үйл ажиллагаанд чиглэсэн ажлууд 2016 онд 95.6 хувийг, 2017 онд 80.3 хувийг эзэлж байна.

**Дүрслэл 2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016, 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажлын судалгаа /тоогоор/**



Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХК-ийн 2016, 2017 оны Бизнес төлөвлөгөө

2.14. Толгой компанийн ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөний зорилтын ихэнх хувийг 3-4 охин компанид чиглэгдсэн боловч дийлэнх нь судлах, танилцуулах гэсэн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой ажлууд эзэлж байна.

2.15. Төлөвлөсөн ажлыг хэнд танилцуулах нь тодорхой бус, ямар шийдвэр гаргах, гаргасан шийдвэр нь ямар үр дүнд хүрэх талаар тогтоосон шалгуур үзүүлэлт байхгүй, гүйцэтгэх хугацааны нарийвчилсан төлөвлөгөө байхгүй байна. Тухайлбал:

- Багануур ХК-нд чиглэсэн: 2016 онд баяжуулах үйлдвэрийн туршилтын ажил хийх, жижиг хэрэглэгчдэд шигшиж ангилсан нүүрс нийлүүлэх;
- “Эрдэнэс таван толгой” ХК: Шинэ зах зээл нээх судалгааны ажлыг эхлүүлэх, хэрэгжүүлэх;
- “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг охин компаниудын өртөг, урсгал зардал, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж хэрэгцээг тодорхойлох;
- “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг охин компаниудын толгой компанитай үүсээд байгаа хуримтлагдсан өр, авлагын асуудлыг хэлэлцэж, бууруулах боломжит хувилбарыг гарган ажиллах;
- “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг охин компаниудын биет болон биет бус хөрөнгөд судалгаа, шинжилгээ хийн хөрөнгийн ангилалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх;
- “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг охин компаниудын 2017 оны мөнгөн урсгалын төлөвлөгөөг гарган дүн шинжилгээ хийж, зардал, хөрөнгө оруулалтын зарцуулалтыг оновчтой болгох;
- “Эрдэнэс таван толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн 2017 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинжилгээ хийж үр өгөөжийг тооцоолох.

2.16. Охин болон хараат компаниуд бизнес төлөвлөгөөг боловсруулж батлуулсны дараа толгой компани бизнес төлөвлөгөөг нэгтгэн боловсруулдаг тул тэдгээрийн уялдаа холбоо хангагдахгүй, толгой компани охин компаниудын бизнес төлөвлөгөөний уялдааг хянах, чиглэл өгөх, удирдах тогтолцоо бүрдээгүй байна.

2.17. Толгой компанийн зорилго, зорилт тодорхойгүй, толгой болон охин компанийн дүрэм уялдаагүй, бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүй сул байгаа зэргээс шалтгаалан “Эрдэнэс Монгол” ХХК охин болон хараат компанийг удирдан зохион байгуулж чадахгүй байна.

***Төрийн өмчийн оролцоотой компаниудыг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн судалгаа хөгжлийн ажлын үр дүнд байгуулсан компаниуд үйл ажиллагаагаа явуулаагүй байна***

2.18. Судалгаа хөгжлийн ажлыг хийснээр 2016 онд 3 охин болон хараат компани, 2017 онд 2 хамтарсан компани байгуулсан боловч тус компаниуд одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх охин компани байгуулах ажлын хүрээнд “Эрдэнэс ассет менежмент” ХХК-ийг үүсгэн байгуулсан боловч үйл ажиллагаа эхлээгүй;
- “Эрдэнэс-Таван толгой” ХК-аас метан хийг ашиглах төслийг шилжүүлэн авч “Эрдэнэс Метан” ХХК-ийг байгуулж, эрлийн гэрээг АМГТГ-тай байгуулсан боловч хайгуулын ажил хийх хөрөнгө оруулалт байхгүй тул үйл ажиллагаа эхлээгүй;
- Металлургийн кокс, ган төмөрлөгийн үйлдвэр байгуулах чиглэлээр “Бэрэн групп” ХХК-тай хамтран “Эрдэнэс Стийл” ХХК-ийг байгуулсан ч хайгуулын талбай тодорхойлогдоогүй тул үйл ажиллагаа эхлээгүй;
- Шивээ-Овоогийн ордыг түшиглэн баригдах эрчим хүчний цогцолборт нийлүүлэгдэх нүүрсний хангамж, нүүрсний нөөц бүрдүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эрдэнэс Шивээ энерги” ХХК-ийг байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан боловч үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

2.19. Судалгаа хөгжлийн ажлын хүрээнд дэд бүтцийн чиглэлээр дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Сэрээгдэх эрчим хүчний шинэ төслийн хүрээнд төслийн урьдчилсан судалгааг хийх, төсөл хэрэгжүүлэх газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлүүдийг авах, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой судалгааг хийх, төслийн ТЭЗҮ-ийг банкны шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулах, хөндлөнгийн зөвлөх баг ажиллуулах, гадаадын зөвлөх ажиллуулах, төсөл хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл авах;
- “Шивээ энерги” цогцолбор төсөл болон “Baganuur Power” төслийн хүрээнд төслүүдийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцах, шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах, дүгнэлт хийх, удирдлагад танилцуулах, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг судлах, шийдвэрлэх арга замыг боловсруулах, төслийн нэгжүүдтэй хамтран ажиллах;
- Таван толгойн цахилгаан станц болон төмөр зам барих төслийн хүрээнд төслүүдийн хийгдсэн ажлуудтай танилцах, мэдээллүүдийг цуглуулах, дүгнэлт хийх, удирдлагад танилцуулах, төслүүдийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодруулах, шийдвэрлэх арга замыг боловсруулах, холбогдох төслийн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах.

2.20. Охин болон хараат компанид хэрэгжүүлэх шинэ төсөл хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж, зөвлөмж хүргүүлэх чиглэлээр хийсэн ажил 2016, 2017 онд байхгүй байна.

***Охин, хараат компаниудын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хууль, дүрэмд нийцүүлэн удирдаж чадаагүй, уул уурхайн технологи ашиглалт, дэд бүтэц, логиистикийг хөгжүүлэх ажил хийгдээгүй байна***

2.21. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 4.1.9.2-т<sup>23</sup> ашигт малтмалын ордын дэд бүтцийг хөгжүүлэх чиг үүргийг тусгагдсан боловч одоогийн байдлаар энэ чиглэлээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах дорвитой ажил хийгдээгүй, хамтарсан хөрөнгө оруулалттай авто зам, төмөр зам, логистикийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий компани байгуулахаар 2016 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан боловч хэрэгжээгүй байна.

2.22. Энэ нь Таван толгойн уурхайгаас Чойр, Ханги чиглэлд барихаар төлөвлөсөн замуудын ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй, уурхай, боомт, шалган нэвтрүүлэх цэгүүдийг эрчим хүчээр хангах хэд хэдэн ажлын анхан шатны бэлтгэл ажил эхлээгүйтэй холбоотой байна.

2.23. Одоогоор нүүрс тээвэрлэлтийг 2012 онд баригдсан 239 км авто замаар явуулж байгаа бөгөөд шинээр хэрэгжүүлэх 9 төслийн хэрэгжилт хангалтгүй байна. **/Хавсралт 2/**

2.24. Ханги, Чойр чиглэлд баригдах замуудын ТЭЗҮ-ийг боловсруулах, Таван толгойн уурхай, авто замын шалган нэвтрүүлэх цэгүүд болон хилийн боомтыг сэргээгдэх эрчим хүчээр хангах, цахилгаан хангамжийн хэмнэлтийн загвар боловсруулах зэрэг төслүүд санхүүжилтгүйн улмаас бэлтгэл ажил эхлээгүй, зарим нь бизнес төлөвлөгөөнөөс хасагдсантай холбоотой ТЭЗҮ<sup>24</sup>-ийг дагалдан боловсруулагдах төлөвлөгөө батлагдаагүй байна.

2.25. Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км авто замыг ЗТБХБЯ /хуучин нэрээр/ “Говийн зам” ХХК-тай 2010 оны 6 дугаар сарын 09-ны өдөр 74 GR-10/146 дугаартай концессын “барих-ашиглах-шилжүүлэх” гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд 2013 онд Хөгжлийн банкны 170.6 тэрбум төгрөгийн зээлээр тус компанийн өмчид шилжүүлэн авснаар сүүлийн 5 жилд зам ашиглалтын хураамжаас 106.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн ч зээлийн төлбөрийг барагдуулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.26. Засгийн газрын 2011 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 257 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 2<sup>25</sup>-т заасныг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр “Энержи ресурс” ХХК-тай А/11/46Б/1 дугаар консорциумын гэрээг байгуулж, нийт 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Гашуун сухайтын хилийн боомтод дэд бүтцийн бүтээн байгуулалтын дараах ажлуудыг гүйцэтгэн 2011 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр ашиглалтад оруулсан байна.

## Хүснэгт 21. Боомтод хийгдсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын судалгаа

|                 |                                                              | /сая төгрөг/    |
|-----------------|--------------------------------------------------------------|-----------------|
| №               | Хэрэгжүүлсэн ажил                                            | Төсөвт өртөг    |
| 1               | Хатуу хучилттай зам, талбай                                  | 9,020.4         |
| 2               | Хурууны хээ картаар машин таних жолооч ба машин таних систем | 1,027.7         |
| 3               | Гадна цахилгаан гэрэлтүүлгийн систем                         | 565.0           |
| 4               | Хилийн мэргэжлийн албадын ажлын байр ба тоноглол             | 592.1           |
| 5               | Авто машины ариутгалын төхөөрөмж ба байгууламж               | 365.2           |
| 6               | Хяналтын пүү нийлүүлэх ба угсрах                             | 170.2           |
| 7               | Боомтын хашаа барих                                          | 253.5           |
| Үүнээс:         | Санхүүжилтийн зардал                                         | 669.319         |
|                 | Зөвлөх үйлчилгээний зардал                                   | 79.200          |
|                 | Томилолт, тээвэр, шатахуун                                   | 5.546           |
| <b>НИЙТ ДҮН</b> |                                                              | <b>12,748.2</b> |

Эх сурвалж: Консорциумын гэрээ, архивын баримтууд, хүлээн авсан комиссын акт

2.27. Дээрх хүснэгтэд дурдсан хатуу хучилттай авто зам, талбай болон тоног төхөөрөмжийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлснээр 12.7 тэрбум төгрөгийг төлсөн боловч 9.0 тэрбум төгрөгийн хатуу хучилттай зам, талбайгаас бусад 3.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглахгүй байна.

<sup>23</sup> “ашигт малтмалын ордын дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”

<sup>24</sup> энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;

<sup>25</sup> 4.2. Гашуунсухайт боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлын санхүүжилт болон уг боомтын авто замын орц, гарцыг 10 урсгалтай болгон өргөтгөх ажлыг 2011 онд багтаан хэрэгжүүлэхийг “Эрдэнэс МГЛ” ХХК-д хариуцуулан зохион байгуулах.



2.28. Цаашид ашиглахгүй байгаа тоног төхөөрөмжийг засварлаж, хил гаалийн үйл ажиллагаанд ашиглах чиглэлээр холбогдох төрийн байгууллагатай хамтарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал:

- Хурууны хээ картаар машин ба жолооч таних систем, гадна цахилгаан гэрэлтүүлгийн систем, авто машины ариутгалын төхөөрөмж, хяналтын пүү зэргийг ашиглахгүй байгаа бөгөөд зарим засвар үйлчилгээний ажлыг 2017 онд шинээр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй;
- Гаалийн мэргэжлийн хяналтын авто машины ариутгал халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

2.29. УИХ-ын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Таван Толгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор тус ордод тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэл хувийг арилжаалах замаар тус уурхайн дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, дамжин өнгөрөх тээвэр, боомт ашиглалт, дэд бүтцийн асуудлаар хөрш орнуудтай хэлэлцээ хийсний үндсэн дээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан боловч тус тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр ажил зохион байгуулаагүй байна.

2.30. “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны бизнес төлөвлөгөөнд “Уул уурхайн технологийн судалгаа, боловсруулалтын төв”-ийг байгуулж, тус төвөөс гаргасан удирдамж, дүгнэлтийг бодлогын түвшинд шийдвэр гаргах үндэслэл болгох зорилгыг тавьсан боловч хэрэгжээгүй байна.

2.31. Тус төвийг байгуулах талаар дараах ажлуудыг хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй, төв байгуулагдаагүйгээс шалтгаалж судалгаанд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлэх, үр ашгийг бий болгох, нөөцийг зохистой удирдах чиглэлийн ажлыг хийж чадаагүй байна. Тухайлбал:

- “Эрдэнэс монгол” ХХК-ийн дэргэд “Эрдэс баялгийн судалгааны төв” байгуулах ажлыг 2016 онд тэргүүн дэд захирлын баг хариуцан ажиллаж төслийн саналыг боловсруулж холбогдох байгууллагуудад танилцуулсан гэх боловч баримт материал байхгүй;
- 2016 оны 10 дугаар сард тэргүүн дэд захирал Б.Ариунболд “Эрдэс баялгийн судалгааны төв” байгуулах асуудлаар Австри улсад ажиллаж, хоёр улсын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны хүрээнд зохион байгуулсан уул уурхайн шинжээчдийн уулзалтын дүнд төсөл дээр хамтран ажиллахаар тохиролцсон гэж тайлагнасан боловч 2017-2018 онд энэ чиглэлээр хийсэн тодорхой ажил байхгүй, үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй газар хэлтэс байхгүй байна.

2.32. Сайн туршлага, технологийг нэвтрүүлж уул уурхайн компаниудын ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөсөн зарим арга хэмжээний хүрээнд олон улсын дэвшилтэт техник технологийг охин хараат компаниудын үйл ажиллагаанд турших, улмаар нутагшуулж, түүнээс гарах үр ашгийг бий болгох зорилгоор дараах томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

- Япон улсын Нагата инженеринг компанитай хамтран Таван толгойн ордод нүүрсийг хуурай аргаар баяжуулах төслийг хэрэгжүүлснээр ус ашиглахгүйгээр нүүрс баяжуулах шинэ технологийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн боловч төсөлд шаардагдах хугацаа, гарах үр дүнг нарийвчлан тооцоогүйгээс тус төсөл зогссон;
- “Шивээ-Овоо” ХК-ийн уурхайн өргөтгөл, техникийн шинэчлэлийн төслийн хүрээнд 2016 онд уурхайн урт хугацааны ТЭЗҮ-ийг боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг Дэлхийн банк болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран шийдвэрлэх зорилготой байсан боловч санхүүжилт шийдэгдээгүйгээс уурхайд өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдээгүй;
- “Багануур” ХК-ийн хүрэн нүүрсийг дулааны боловсруулалт хийх замаар хагас коксжуулж нүүрс дэх дээдэмхий бодисын агууламжийг багасгах технологийг ашиглан жилдээ 190.0 мян.тн түүхий нүүрсээр 100.0 мян.тн утаагүй түлш, 11.4 мян.тн давирхай үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барьж 2017 оны ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч санхүүжилтэд шаардагдах 22.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шийдэгдээгүй тул хэрэгжээгүй.

2.33. Уурхайн ашиглалт, технологи, логистикийн чиглэлийн ажлууд нь компанийн нийт төлөвлөгөөт ажлын 39.8 хувийг эзэлдэг бөгөөд “Шивээ-Овоо” ХК 27.0 хувь, “Багануур” ХК 26.5 хувь, “Эрдэнэс-Таван толгой” ХХК 19 хувь, “Гашуун сухайт авто зам” ХК 14 хувийг тус тус эзэлж байгаагаас үзэхэд төлөвлөсөн ажил энэ хэмжээгээр хэрэгжихгүй байна.

2.34. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн дэд бүтцийн судалгааг боловсруулж, шийдвэрлүүлэх, компаниудын техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлуулах, металлургийн кокс, ган төмөрлөгийн үйлдвэрийн төслийн эрчим хүч, ус хангамж, тээвэрлэлтийн судалгаа хийх, Таван толгойн цахилгаан станц болон төмөр замын төслүүдийн хүрээнд судалгаа гаргах зэрэг ажлууд эхлээгүй, анхны төслийн шатанд байгаа нь үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт засаглал,



хангалтгүй байгаагаас “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд заасан<sup>26</sup> чиг үүрэг хэрэгжээгүй байна.

**Төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж ажиллаагүй байна**

2.35. УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 2 дугаар зүйлийн 1.3<sup>27</sup>-т заасныг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК олон нийтийн эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, засаглал болон үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилгоор хөндлөнгийн хяналт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.

2.36. Тус компанийн мэдээллийг түгээх гол суваг нь олон нийттэй харилцах алба, цахим хуудас, хэвлэмэл байдлаар гаргасан жил бүрийн үйл ажиллагааны тайлан бөгөөд 2016 оны сүүлийн хагас жилээс эхлэн үйл ажиллагааны тайланг хэвлэж, УИХ болон байнгын хороодод танилцуулж эхэлсэн байна.

2.37. Компанийн хэвлэн гаргасан 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллүүдийг товч бөгөөд хэт ерөнхий байдлаар тусгасан байна. Үүнд:

- Нүүрсний ордуудын нөөцийн мэдээлэл,
- Шинээр авсан хайгуулын тусгай зөвшөөрөл,
- Төрийн эзэмшил хувь нь шилжиж ирэх боломжтой стратегийн орд,
- Зэсийн баяжмал, нүүрсний олборлолт, борлуулалт, экспорт,
- Хууль эрх зүй, хувьцаа эзэмшигчид,
- Компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц,
- Засаглалыг сайжруулах чиглэл,
- Байгаль орчин нөхөн сэргээлт, тээвэр, дэд бүтэц,
- Санхүүгийн ерөнхий мэдээлэл, аудитын дүгнэлт,
- Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий тайлан,
- Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүд.

2.38. Компанийн үйл ажиллагааны тайланг салбарын нэгдсэн чуулга уулзалтын үеэр Засгийн газар, яам, бусад төрийн байгууллагууд, гадаадын зочид, төлөөлөгчдөд танилцуулсан боловч иргэд, олон нийтэд хүргэж, мэдээлсэн эсэх нь тодорхой бус байна.

2.39. Засаглалын үнэлгээг сайжруулах зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос төлөвлөгөөг баталж, дараах мэдээллийг олон нийтэд ил тодоор мэдээлэх үүрэг өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн мэдээ,
- Нийгмийн үйлчилгээнд зориулан төлсөн төлбөр, нийтийн өмчид хөрөнгө оруулсан байдал,
- Засгийн газрын өр төлбөрийг барагдуулсан байдал,
- Охин компаниудын орлого, зарлагын хувь хэмжээ,
- ТӨК болон ЗГ хоорондын татвар болон бусад төрлийн орлого татаасны хэмжээ,
- ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал,
- Хамтарсан компаниудад эзэмших хувь эзэмшлийн хэмжээ,
- Байгууллагын ёс зүйн дүрэм гэх мэт

2.40. Компанийн цахим хуудсанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг мэдээлээгүй, охин болон хараат компаниуд олон нийтэд ил тод байлгах мэдээллийг тухай бүр байршуулаагүй, Байгалийн баялгийн засаглалын болон Нээлттэй нийгмийн хүрээлэн, бусад хөндлөнгийн байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагаа хангалтгүй, тэдний өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.41. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-өөс дээрх дурдсан мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгаа нь Компанийн тухай

<sup>26</sup> 4.1.2.4 ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх.

4.1.4.3. хөрөнгийн өгөөжийн зохистой түвшнийг хангасан эрдэс баялгийн болон түүнийг дагасан дэд бүтцийн салбарын төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалт хийх;

4.1.9.1. ашигт малтмалын ордыг түшиглэн ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах, түүний хувьцааг эзэмших;  
4.1.9.3. ашигт малтмалын ордын ложистик, бүтээгдэхүүн тээвэрлэх үйлчилгээ, дамжуулан тээвэрлэх, агуулахын болон гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ эрхлэх.

<sup>27</sup> эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх

хуулийн 79 дүгээр зүйлийн 3.2<sup>28</sup> дахь заалтыг зөрчсөн, засаглалыг сайжруулах ажлын хүрээнд “Мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулж, батлуулаагүйтэй холбоотой байна.

2.42. Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд байршуулах шаардлагатай мэдээлэлд хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээ, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан зэргийг он тус бүрээр харуулаагүй нь олон нийтийн хараа хяналтаас хөндий байх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.43. Цаашид компанийн үйл ажиллагаатай холбоотой сар, улирал тутамд гарсан өөрчлөлт, шинэчлэлт, хувьцаа, засаглал, менежмент, өрсөлдөх чадварыг сайжруулсан талаарх мэдээлэл, олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай мэдээллүүдийг “Олон нийттэй харьцах алба”-аар дамжуулан мэдээлэх ажлыг тухай бүр гүйцэтгэх, Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайланд дурдагдсан зарим охин компаниудын санхүүгийн тайлан, үйлдвэрлэл, борлуулалтын дүн мэдээг нийтлээгүй алдаа дутагдлыг арилган стандартад заасны<sup>29</sup> дагуу хууль, журамд заасан хугацаанд нь мэдээлж хэвших шаардлагатай байна.

2.44. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ охин болон хараат компанийг үүсгэн байгуулах шийдвэрийг гаргахдаа УИХ болон Засгийн газраас баталсан тогтоолыг үндэслэн “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-т тусгагдсан үндэсний хэмжээний томоохон хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын болон улсын хөгжилд хувь нэмэр оруулах зорилтыг тавьсан байна.

2.45. Гэвч охин болон хараат компаниудын цахим хуудас болон бусад баримтаас харахад компанийг байгуулсан шийдвэр, удирдлагын талаарх мэдээлэл, компанийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, эрх үүрэг, зохион байгуулалтын бүтэц, өмчлөлийн талаарх мэдээлэл зэргийг олон нийтэд ил тодоор мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

## Хүснэгт 22. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2009-2018 онд байгуулсан охин болон хараат компаниудын судалгаа

| № | Охин компанийн нэр          | Үйл ажиллагааны чиглэл                             | Байгуулагдсан огноо |
|---|-----------------------------|----------------------------------------------------|---------------------|
| 1 | Мон-Атом ХХК                | Ашигт малтмалын геологийн судалгаа, ТЭЗҮ хийх      | 2009.03.18          |
| 2 | Эрдэнэс Шивээ энерги ХХК    | Гадаад худалдаа, уул уурхайн зөвлөгөө өгөх         | 2016.3.04           |
| 3 | Эрдэнэс Метан ХХК           | Газрын тосны чиглэлээр эрэл, хайгуул судалгаа хийх | 2016.02.25          |
| 4 | Эрдэнэс ассет менежмент ХХК | Уул уурхайн зөвлөгөө мэдээлэл                      | 2017                |
| 5 | Таван толгой түлш           | Шахмал түлшний үйлдвэрлэл, гадаад худалдаа         | 2018.5.18           |

2.46. Охин болон хараат компаниудын 50 хувь нь үндсэн үйл ажиллагааг эхлээгүй, урсгал зардлын хэмжээнд санхүүгийн тайланг гаргасан боловч мэдээллийн ил тод байдлын стандарт шаардлагыг бүрэн хангах хэмжээнд хүрэхгүй байна.

2.47. Төрийн өмчит уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг, санхүү, нийгэм, байгаль орчин зэрэг томоохон хүчин зүйлс нөлөөлснөөс гарах үр дүн өөрчлөгддөг боловч үүссэн нөхцөл байдлыг олон нийтэд ил тод тайлбарлаж мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Олон жилийн туршлагатай “Шивээ-Овоо” ХК, “Багануур” ХК болон шинээр байгуулсан охин, хараат компаниудын цахим сайтад байгууллагын үйл ажиллагааны товч тойм, санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүй, дүрэм журам зэрэг тогтмол давтагддаг мэдээллийн чанартай зүйлсийг мэдээлсэн боловч бусад зайлшгүй ил тод байлгах шаардлагатай мэдээллийг байршуулаагүй байна.
- Зарим охин компаниуд хүний нөөц, үйлдвэрчний эвлэл, олон нийтийн үйл ажиллагаа зэргийг олон нийтэд мэдээлээгүй байна.

2.48. Охин компани хэлбэрээр байгуулагдсан дараах аж ахуй нэгжүүдийн талаарх ойлголт нийгэмд тодорхой бус, үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод болоогүй, үндсэн болон дүрэмд

<sup>28</sup> компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах

<sup>29</sup> “Төрийн өмчит компани нь уул уурхай, газрын тос, болон байгалийн хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудад өөрийн эзэмшиж буй хувь эзэмшлийн хэмжээг ил тайлагнах”

заасан чиг үүргүүд хоорондоо уялдаагүй, үйл ажиллагаа анх байгуулсан зорилго, зорилтдоо хүрээгүй, нийгэм, эдийн засагт үзүүлсэн эерэг нөлөөлөл байхгүй, тодорхой үр дүнд хүрээгүй байна. **IX Хэвсрэлт 3/**

2.49. Энэ нь компанийг байгуулахдаа зорилго, зорилтыг тооцоо, судалгаа муутай тооцоолж төлөвлөснөөс шалтгаалан хөрөнгө, санхүүжилтийн асуудал нь шийдэгдэхгүйд хүрч, үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсноос шалтгаалан нийт төлөвлөсөн ажлын 27.3 хувь нь удирдлагад танилцуулагдаад зогссон, 9.1 хувь нь цаашид хэрхэх нь тодорхойгүй, 0.8 хувь нь гадаад хүчин зүйлсээс шалтгаалан хэрэгжээгүй бөгөөд “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3 дугаар зүйлийн 7.6<sup>30</sup>-д заасныг хэрэгжүүлээгүй, иргэний нийгмийн хяналтыг тогтоох нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

2.50. Цаашид байгууллагын үйл ажиллагааны гол өөрчлөлтүүд, санхүүгийн гол гол үзүүлэлтүүд, бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, түүний нөлөөлөл, хөндлөнгийн хууль, хяналтын байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, дүгнэлт, гаднын эерэг, сөрөг хандлага зэргийг энгийн, ойлгомжтой байдлаар бэлтгэж, сонирхогч талуудад тодорхой хугацаанд байнга шинэчлэн хүргэх ил тод байдлын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

**Төрийн өмчийн оролцоотой компаниудтай байгуулсан менежментийн гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй байна**

2.51. “Эрдэнэс Монгол” ХХК 2016-2018 онд толгой охин компаниудын хоорондын харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий дараах бодлогын баримт бичиг, журмуудыг боловсруулж ТУЗ-өөр батлуулжээ. Тухайлбал:

**2016 онд:**

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг,
- “Эрдэнэс Монгол” ХХК-с охин болон хараат компанид хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэх журам,

**2017 онд:**

- Хүний нөөцийн стратегийн бодлогын баримт бичиг,
- “Эрдэнэс Монгол” ХХК-ны охин, хараат компаниудын өмч эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам,

**2018 онд:**

- Эрсдэлийн удирдлагын хорооны журам

2.52. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016, 2017 оны бизнес төлөвлөгөөнд удирдлагын менежментийг сайжруулах зорилтын хүрээнд толгой болон охин компани хоорондын харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч энэ чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ дутагдалтай, менежментийн үйлчилгээ үзүүлэх баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй байна.

2.53. Энэ нь тус компани дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу охин компаниудын үйл ажиллагаанд менежментийн үйлчилгээг хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхой бус, одоогийн зохион байгуулалтын бүтцээр уг ажлыг ямар газар, нэгж хэрэгжүүлэхийг чиг үүрэгт тусгаагүйтэй холбоотой байна.

2.54. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 7.15-д заасны дагуу охин компаниудад үзүүлэх менежментийн үйлчилгээний чиглэл түүнийг хэрхэн ямар зарчмаар үзүүлэх, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосон тооцоо, судалгааг ТУЗ-өөр хэлэлцүүлээгүй, шийдвэр гаргуулаагүй байна.

2.55. “Эрдэнэс Монгол” ХХК нь 2016, 2017 онд өөрийн охин компани болох “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-тай “Менежментийн төлбөрийн гэрээ”-г байгуулж, дараах төлбөрийг авахаар санхүүгийн тайланд авлагаар бүртгэж, тайлагнажээ.

<sup>30</sup> “төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулж, нээлттэй, ил тод, үр ашигтай болгох ба эрдэс баялгийн салбар хариуцсан Засгийн газрын бүх шатны байгууллагын ажлын тогтолцоо, зөвшөөрөл олголт, стандарт, хугацаа зэргийг нийтэд мэдээлж, иргэний нийгмийн хяналтыг тогтоох”

**Хүснэгт 23. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016-2018 оны менежментийн төлбөрийн авлагын судалгаа** /сая төгрөгөөр/

| Охин компанийн нэр         | Менежментийн гэрээний төлбөр |                              |                    |                              | Санхүүгийн тайланд тусгасан нийт авлага |
|----------------------------|------------------------------|------------------------------|--------------------|------------------------------|-----------------------------------------|
|                            | 2016                         |                              | 2017               |                              |                                         |
|                            | Авлагаар бүртгэсэн           | Мөнгөөр хүлээн авч бүртгэсэн | Авлагаар бүртгэсэн | Мөнгөөр хүлээн авч бүртгэсэн |                                         |
| “Эрдэнэс таван толгой” ХХК | -                            | -                            | 4,023.7            | -                            | 4,023.7                                 |
| “Багануур” ХК              | 3,152.6                      | -                            | 1,013.8            | -                            | 4,166.4                                 |
| “Шивээ овоо” ХХК           | 1,277.3                      | -                            | 478.3              | -                            | 1,755.6                                 |
| Нийт дүн                   | 4,430.0                      | -                            | 5,515.9            | -                            | 9,945.9                                 |

2.56. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 4<sup>31</sup>, 15 дугаар зүйлийн 2<sup>32</sup> дахь заалтыг тус тус зөрчин “Эрдэнэс таван толгой” ХХК-тай хамтран 2017 онд менежментийн оновчтой бодлого хэрэгжүүлсний үр дүнд зарим томоохон арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах үйлчилгээ үзүүлсний төлбөрт тус компаниас нийт 4.0 тэрбум төгрөгийг авахаар санхүүгийн тайланд тусгасан боловч тус компанид өгөх өглөгийг бүрэн барагдуулаагүй гэсэн шалтгаанаар “Менежментийн үйлчилгээний гэрээ”-г байгуулаагүй байна.

2.57. “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХХК-тай “Менежментийн төлбөрийн гэрээ”-г байгуулсан боловч тус гэрээнд хэрэгжилтийг дүгнэх заалтыг тусгаагүй байсныг 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулан толгой компанийн эрх, үүргийг тусгасан байна.

2.58. “Менежментийн гэрээ”-ний биелэлтийг судалж үзэхэд “Багануур” ХК-ийн ТУЗ дахь өөрийн компанийн төлөөллөөр дамжуулан тус компанийн зөвхөн өр төлбөртэй холбоотой ойрын хугацааны тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

**Хүснэгт 24. Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх судалгаа**

| Толгой компанийн эрх үүрэг                                                                                                                                             | Менежментээр хийж гүйцэтгэсэн ажил                                                                                                                                                                                                                                                                                |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Гадаадын хөрөнгө оруулалттай төслийг Засгийн газарт танилцуулах                                                                                                        | “Монгол нүүрс” төслийн хүрээнд Дэлхийн банк, Япон улсын Засгийн газраас манай улсын Засгийн газарт олгосон дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний төлбөрийн өрийг тухайн нүүрсний уурхайд оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцуулах ажлын хэсгийн саналыг Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоолд тусгуулсан. |
| Охин компанийн уурхай, үйлдвэрт олон жил ашигласан шаардлага хангахгүй тоног төхөөрөмжийг шинэчлэх                                                                     | 2018-2020 онд эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан “Багануур” ХК-ийн хэвийн ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор техник технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай 163.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдэх асуудлыг судалсан.                                                  |
| Охин болон хараат компаниудын засаглалыг бэхжүүлэх, бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгжүүлэх, бодлогын дэмжлэг, тусалцаа үзүүлнэ | “Багануур” ХХК-ийн ТУЗ-ийн 6 удаагийн хурлын удирдамжид хуулийн хянан нийцүүлэлт хийж зөвлөмж өгсөн.<br>Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээг дүгнэж сунгасан.                                                                                                                                                |

Эх сурвалж: Менежментийн гэрээ дүгнэсэн ажлын тайлан

2.59. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьд “Менежментийн гэрээ”-ээр гүйцэтгэх гол үүрэг нь охин компаниудад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхээр тусгасан боловч төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, тодорхой үр дүнд хүрээгүй байгаа нь тус компаниас явуулж байгаа менежмент нь зохистой, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхгүй байгаатай холбоотой юм.

2.60. Түүнчлэн охин компаниудын санхүүгийн чадавх сайжраагүй, толгой компанид төлөх менежментийн төлбөрийн өр төлбөрийг жил бүр нэмэгдсээр байна.

2.61. Цаашид толгой компанийн зүгээс охин компаниудад хэрэгжүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалтыг татах, уурхайн техник технологийн оновчтой шийдэл гаргах, шинэчлэл хийх, зураг төсөл боловсруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэх хэмжээнд

<sup>31</sup> Компани гэрээ байгуулах замаар охин компаниасаа менежментийн төлбөр авч болно.

<sup>32</sup> Компани охин компаниаа менежментийн төлбөрийн гэрээ байгуулж, төлбөр авах бөгөөд төлбөрийн хэмжээг гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл батална.

удирдан зохион байгуулж, үр дүнд хүргэснээр “Менежментийн гэрээ”-ний төлбөрийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.


2.62. Мөн охин компаниуд үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулахад толгой компанийн зүгээс үзүүлэх төлөвлөлт, судалгаа, үнэлгээ тооцоолол, хууль, эрх зүй, байгаль орчин, дэд бүтэц, маркетинг, худалдаа, санхүүгийн үйлчилгээ зэргийг багтаасан менежментийн цогц үйлчилгээний бодлогыг бий болгож, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1.1-д заасны дагуу байгаль орчны болон бусад чиглэлийн ажилд үзүүлэх менежментийн үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлж, дорвитой үр дүнд хүрч ажиллах нь зүйтэй байна.

**Төрийн өмчийн оролцоотой компаниудын санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт, нэгдсэн бодлого байхгүй байна**

2.63. “Эрдэнэс Монгол ХХК” байгуулагдсанаас хойш хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах нэгжийг байгуулсан боловч өнөөдрийг хүртэл компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1<sup>33</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, батлуулаагүй байна.

2.64. “Эрдэнэс Монгол” ХХК нь Гашуун сухайт-Таван толгой чиглэлийн авто замын орлогоор санхүүжиж байгаа нь БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай болгож байна.

### Дүрслэл 3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн замын орлого болон нүүрсний зах зээлийн үнийн судалгаа



2.65. Дүрслэлээс харахад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн орлого нүүрсний үнээс ихээхэн хамааралтай<sup>34</sup> байгаа тул тус компанийн орлого тогтворгүй байх эрсдэлтэй байна.

2.66. Монгол Улсад дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр дараах 7 төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарснаас шалтгаалан цаашид Гашуун сухайт-Таван толгой чиглэлийн авто зам хэр удаан оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болж байна.

### Хүснэгт 25. Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн дэд бүтцийн судалгаа

| № | Чиглэл                     | Төрөл             | Хүчин чадал | Явц                                        |
|---|----------------------------|-------------------|-------------|--------------------------------------------|
| 1 | Тавантолгой-Гашуунсухайт   | Төмөр зам         | 30 сая тонн | ЭТТ-МТЗ хамтран хэрэгжүүлэх шийдвэр гарсан |
| 2 | Тавантолгой-Гашуунсухайт   | Зэрэгцээ авто зам | 25 сая тонн | Гүйцэтгэгчтэй хэлэлцээр хийх шатанд        |
| 3 | Тавантолгой-Цагаан дэл уул | Авто зам          | -           | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан          |
| 4 | Тавантолгой-Ханбогд-Ханги  | Авто зам          | -           | Концессын зүйлийн жагсаалтад орсон         |
| 5 | Тавантолгой-Зүүнбаян       | Төмөр зам         | -           | Засгийн газрын шийдвэр гарсан              |
| 6 | Тавантолгой-Зүүнбаян       | Авто зам          | -           | Засгийн газрын шийдвэр гарсан              |
| 7 | Тавантолгой-Гашуунсухайт   | Авто зам /239 км/ | 18 сая тонн | Одоо ажиллаж байгаа                        |
|   | Нийт                       |                   | 73 сая тонн |                                            |

<sup>33</sup> Компани нь Монгол Улсын хууль тогтоомж болон компанийн засаглалын олон улсын шалгуур үзүүлэлтэд нийцсэн, бизнесийн цар хүрээгээ өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлоготой байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

<sup>34</sup> Корреляцийн коэффициент 0.87 /t-stat 3.3/



2.67. Таван толгойн бүлэг ордоос олборлолт хийн үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд бүрэн хүчин чадлаар ажиллах тохиолдолд 52 сая тонн нүүрс олборлохоор ТЭЗҮ-д тусгагдсан байна.Тухайлбал:

- “Эрдэнэс таван толгой” ХК 35 сая тонн,
- “Таван толгой” ХК 2 сая тонн,
- “Энержи ресурс” ХХК 15 сая тонн.

2.68. Гэтэл дээр дурдсан авто зам болон төмөр замын шинэ төсөл хөтөлбөрүүдийн нийт хүчин чадал нь уурхайнуудын олборлох хүчин чадлаас хэт давсан байгаа нь цаашид эдийн засгийн ач холбогдлын хувьд сөрөг үр дагавар үзүүлж, хөрөнгө оруулалтыг нөхөх боломжгүйд хүргэх эрсдэлтэй байна.

2.69. Гашуун сухайт-Таван толгойн 239 км авто зам хэрэгцээгүй болох, Хөгжлийн банкны 170.6 тэрбум төгрөгийн зээлийг төлөх эх үүсвэр эрсдэлд орох нөхцөл үүссэн байхад тус компани тогтвортой орлого олох хөрөнгө оруулалтад чиглэсэн, түүхий эдийн ханш унасан тохиолдолд өгөөжөө өгөх, компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломжтой хөрөнгө оруулалтын бодлогогүй байна.

2.70. Толгой компаниас охин компаниудад хөрөнгө оруулалт нэрээр зээл олгож байгаа нь охин компаниудад хөрөнгө оруулалт болохгүй, цалин, түрээс зэрэг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулагддаг байна.

2.71. Охин компаниудын урсгал зардлыг санхүүжүүлж, үйл ажиллагааг дэмжсэн боловч зээлээр санхүүжсэн охин компаниудын үйл ажиллагаа зогсонги хэвээрээ, толгой компани шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлээгүй байна.

2.72. Цаашид “Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэн цэвэр ашгийг нэмэгдүүлэх, төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх зэрэг санхүүгийн хөрөнгө нөөцийн удирдлагын нэгдсэн бодлогыг боловсруулж, менежментийн орлогоор үйл ажиллагааг санхүүжүүлэх нь зүйтэй юм.

2.73. Засгийн газрын 2015 оны 70 дугаар тогтоолоор “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг 51 хувь хүртэл бууруулж, хувьцааг Монголын хөрөнгийн биржээр нийтэд арилжаалж, нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна.

2.74. Дээрх ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт 2016 оны А/126 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн “Багануур” ХК-ийн хувьцааг борлуулахаар шийдвэрлэсэн боловч дараах шалтгаанаар Монголын хөрөнгийн биржийн шаардлагыг хангаагүй тул амжилтгүй болж, андreyтерын үйлчилгээний төлбөрт “Ти Ди Би капитал” ХХК-д 330.0 сая төгрөгийг төлсөн нь үр ашиггүй зардал болжээ. Тухайлбал:

- “Багануур” ХХК-ийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг “Алтайн Гянт” ХХК эзэмшдэг бөгөөд тус асуудал нь шүүхэд хянагдаж байгаа;
- Тус компани нийт 39.7 тэрбум төгрөгийн өр төлбөртэй.

2.75. Энэ нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн маргаантай, хуримтлагдсан өр төлбөр ихтэй байхад 51 хувь хүртэл хувьчлахаар гаргасан Засгийн газрын шийдвэр оновчгүй, “Эрдэнэс Монгол” ХХК хөрөнгө, санхүүгийн нөөцөө удирдах эрх мэдэл байхгүй байгаатай холбоотой байна.


**Охин хараат компаниудын санхүү, хөрөнгийн удирдлага, хувьцааны хуваарилалт, ногдол ашгийн олголтыг үр дүнтэй удирдаж чадахгүй байна**

2.76. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.2<sup>35</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс охин, хараат компаниудын хувьцааны хуваарилалт, ногдол ашгийн бодлого батлагдаагүй, компани байгуулагдсанаас хойш ногдол ашиг төвлөрүүлж,

<sup>35</sup> ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг холбогдох хуулийн дагуу төвлөрүүлж, хуваарилах

хуваарилаагүй байгаа нь охин, хараат компаниуд ашиггүй ажилладаг, зарим компаниуд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

#### Дүрслэл 4. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин, хараат компаниудын 2016-2017 оны цэвэр ашгийн судалгаа



#### Төрийн өмчийн оролцоотой компаниудад тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна

2.77. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт эрдэс баялгийн салбарын мэргэжлийн хяналт-шинжилгээ үнэлгээ, аудитын тогтолцоог бэхжүүлж, хариуцлагын механизмыг боловсронгуй болгохоор заасан боловч “Эрдэнэс Монгол” ХХК охин, хараат компаниудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.

2.78. Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, дотоод хяналтын нэгдсэн бодлогыг тодорхойлоогүй байгаа нь толгой компани охин болон хараат компаниудын үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, өр төлбөр, санхүүгийн хүндрэл, техник технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын болон бусад эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй болгосон байна.

2.79. Цаашид толгой болон охин, хараат компаниудын үйл ажиллагаа хууль, УИХ, ЗГ болон компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх, хэрэгжилт, үр дүнг тооцох, газар, хэлтсээс энэ чиглэлээр гаргасан санал санаачилгыг удирдлагын түвшинд дэмжин ажиллах шаардлагатай байна.

## **Дүгнэлт**

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах 2 зорилтын хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий ордуудын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшүүлж, тэдгээр ордуудад төрийн оролцоог хэрэгжүүлж, менежмент хийж, ашгийг төвлөрүүлэх зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг байгуулсан боловч төрөөс хэрэгжүүлсэн бодлого, чиглэл дутмаг байснаас үйл ажиллагаа нь үндсэн зорилго, чиглэлийн дагуу явагдаж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө зорилгын түвшинд хангаагүй байна.
- Компани урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, дүрмийн дагуу өөрийн орлогыг бүрдүүлэх нөхцөл бүрдээгүйгээс жилийн нийт орлогын 86.3 хувийг эзэлж буй замын хураамжийн орлогоор үйл ажиллагаагаа явуулж байна.
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн олон удаа өөрчлөгдөж тогтвортой ажиллаагүйгээс Компанийн тухай хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, 2017 оныг хүртэл дотоод хяналтгүй ажиллаж иржээ.
- Компанийн бүтцийг зорилго, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт нийцүүлэн оновчтой тогтоогоогүйгээс орон тооны байнгын өсөлт, ажилтнуудын ажлын ачаалал багатай байх үйл явц ажиглагдаж байна.
- Концессын “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр баригдсан Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км авто замыг Засгийн газрын 2013 оны 299 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлснээс хойш зам ашиглалтын хураамжаас 106.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, зарцуулсан боловч концесс эзэмшигчид Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон 170.6 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн төлбөрийг төлж эхлээгүй байна.
- “Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компаниуд худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин, хараат компаниудын 2016 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-аар дахин аудит хийлгэсэн боловч санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт гаргаагүй байна.
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүү, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого байхгүйгээс охин, хараат компаниудад үзүүлэх менежментийн үйлчилгээний чиглэл тодорхойгүй, уул уурхайн технологи ашиглалт, дэд бүтэц, логистикийг хөгжүүлэх ажил хийгдээгүй, судалгаа хөгжлийн ажлын үр дүнд байгуулсан охин, хараат компаниудын ихэнх нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

## **Зөвлөмж**

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:**

1. “Ирээдүйн өв сангийн тухай” хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, “Эрдэнэс Монгол” ХХК-ийг төрөөс байгуулсан зорилгод нийцүүлэн тус компанийн дүрмийг шинэчлэх.

### **“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад:**

1. Дотоод хяналтын тогтолцоог Олон Улсын стандартад нийцүүлэн бүрдүүлж, компанийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааг холбогдох хууль, дүрмийн дагуу хянаж ажиллах.

### **“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захиралд:**

1. Компанийн дүрмийг “Ирээдүйн өв сангийн тухай” хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль, “Эрдэнэс Монгол” ХХК-ийг төрөөс байгуулсан зорилгод нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
2. Компанийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх;
3. Компанийн зохион байгуулалтын бүтцийг үндсэн чиг үүрэгт нийцүүлэн үр ашигтай байдлаар тогтоож, батлуулах;
4. Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км авто замын 170.6 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
5. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуульд нийцүүлэн зохион байгуулах, охин болон хараат компаниудын худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
6. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, АОУС 10-ыг үндэслэн нэгдлийн хэмжээнд нэгдсэн санхүүгийн тайланг гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж байх;
7. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүү, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
8. Охин, хараат компаниудын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, байгуулсан зорилгыг хэрэгжүүлэх чиглэлээр менежментийн гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах;

## “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ирүүлсэн санал



### ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

14240 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Чингисийн өргөн чөлөө 15, Моннис тауэр, 15 дугаар давхар,  
Утас: 7555 3399, И-мэйл: info@erdenesmongol.mn,  
Вэбсайт: www.erdenesmongol.mn, УБД: 9011014002

2019.01.10 № 02/61  
танай 2018.12.31-ны 01/2604 -т

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

#### Санал хүргүүлэх тухай

Танай 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01/2603 тоот “Тайлангийн төсөлд санал авах тухай” албан бичигтэй танилцан дараах хариу тайлбар, тодруулгыг үүгээр хүргүүлж байна.

“Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн үйл ажиллагааны журам”-ыг ТУЗ-ийн 2017 оны 23 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал томилохтой холбоотой харилцааг Засгийн газар (цаашид “ЗГ” гэх)-ын 2016 оны 104 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийг шинэчлэн батлах хүртэл Хүний хөгжил сангийн тухай хуулиар зохицуулдаг байсан. Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүр 1 хүний, Засгийн газар 6 хүний нэрийг тус тус дэвшүүлж, тэдгээрийг ЗГ томилно” гэж заасны дагуу дээрх бүрэлдэхүүнийг оролцуулан ЗГ-аас шууд томилдог байсныг уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг “Эрдэнэс Монгол” ХХК-аас санаачлан боловсруулж улмаар батлуулснаар компанийн засаглалын бүтцийг ЗГ-аас шууд томилдог эрх зүйн харилцааг хүчингүйд тооцуулж компанийн хуулиар уг харилцаа зохицуулагдах эрх зүйн боломж бүрэн нээгдсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь өөрийн үйл ажиллагааны журмын хүрээнд аливаа томилгоотой холбоотой бүхий л дүгнэлтийг гарган ажиллаж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах ажлыг ТУЗ-ын дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодод нээлттэй сонгон шалгаруулах зарчмаар 2016, 2017 онуудад зарласан бөгөөд уг сонгон шалгаруулалтын үр дүнд шалгуур хангасан нэр бүхий 3 этгээдийн материалыг хувьцаа эзэмшигчийн хуралд хүргүүлснээр Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 01 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилсон. ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан болно.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь хэсэгт “Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах”, ЗГ-ын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.19 дахь хэсэгт “ТУЗ нь жилд 1-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчид ажлаа тайлагнана” гэж заасныг бүрэн хангуулж жил бүр тайланг боловсруулж өөрийн хувьцаа эзэмшигч буюу ЗГ-т бичгээр хүргүүлдэг.

0000007



“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан зохион байгуулалтын бүтцээр ТУЗ-ын дэргэдэх “Дотоод хяналтын нэгж” (цаашид “ДХН” гэх)-ийг бий болгож, дотоод хяналт хийх боломжийг бүрдүүлсэн байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн дэргэдэх ДХН-ийг гурван хүний орон тоотой анх үүсгэн байгуулж, мөн 2017 оны 1 дүгээр сард ТУЗ-ийн дэргэдэх “Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны журам” болон хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хуваарийг баталсан. Ингэснээр тус компанийг байгуулагдсанаас хойш орхигдоод байсан дотоод хяналтын тогтолцоо, түүний бие даасан, хараат бусаар явагдах хяналтын ажлыг эхлүүлэх, мөн түүнчлэн толгой компанийн болон охин, хараат компаниудын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийх, компанийн сайн засаглалын зарчимд нийцүүлэн холбогдох хууль, журам, стандартын дагуу ажиллаж буй эсэхэд ДХН-ийн үйл ажиллагааг төвлөрүүлсэн юм. ДХН нь ТУЗ-ийн баталсан төлөвлөгөө болон ТУЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу 2017 онд “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний харьяа охин, хараат нийт 11 компанид хяналт, шалгалтын ажлыг дангаар буюу Санхүүгийн үйл ажиллагааны аудит, мониторингийн хэлтэстэй хамтран гүйцэтгэсэн.

2018 онд Дотоод аудитын дүрэм болон үйл ажиллагааны төлөвлөгөөг шинээр батлуулсан бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны худалдан авах үйл ажиллагаанд нийцлийн аудит хийж, Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны хурлаар өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан нийт тогтоолуудын хэрэгжилт 9 сард 56%-тай байсан бол 10 сард 78%, тэмдэглэлүүдийн хэрэгжилт 69%-тай байсан бол 10 сард 76% болж ахисан үзүүлэлттэй байна. Хэрэгжих шатандаа байгаа, мөн хугацаа хэтэрсэн тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах талаар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод аудитын нэгжийг байгуулснаар:

- Толгой болон охин компанийн хүрээнд орхигдоод байсан дотоод болон гадаад хяналтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна;
- Дотоод аудит нь “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компаниудын санхүү, үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч, ТУЗ-ийг мэдээллээр ханган ажиллаж байна;
- Дээрх мэдээлэл нь групп компанийн хэмжээнд эрсдэлийн шинжилгээ хийх, дотоод хяналтыг хөгжүүлэх үндэслэл болно;
- Гэнэтийн болон таамаг мэдээллийн дагуу ТУЗ нь шууд, цаг алдалгүй шийдвэр гарган шалгалтын ажлыг гүйцэтгүүлэх, үүнд үндэслэн шийдвэр гаргах боломжтой болсон;
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлан гаргасан тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг цаг тухай бүрд нь хангуулан ажиллах нөхцөл бүрдсэн.

| № | Хийж гүйцэтгэх ажил                                          | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                    |
|---|--------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй | Компанийн стратеги төлөвлөгөө батлагдсантай уялдуулан нэгжийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Дотоод Аудитын нэгжийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 12 дугаар сард ТУЗ-өөр батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна |

|   |                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2 | Засаглалыг хангалттай түвшинд хөгжүүлээгүйгээс ТУЗ-ийн шийдвэр гаргалт удаашралтай                                                                                                         | Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, тэмдэглэлийн төсөлд цаг тухай бүрд нь санал өгч, батлан гаргасан тогтоол тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах ажлуудыг заасан хугацаанд зохион байгуулж ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх Цалин хөлсний хороо, Нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо тус бүр хуульд заасан үүргээ биелүүлэн ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг холбогдох хороодод томилон ажиллуулж байна                      |
| 3 | Эрсдэлд суурилсан менежментийн арга барил хангалтгүй                                                                                                                                       | Компанийн Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг боловсруулан 2018 оны 4 дүгээр сард ТУЗ-өөр батлуулсан. Мөн Эрсдэлийн удирдлагын хороог 5 дугаар сард байгуулж, хорооны ажиллах журмыг баталсан. Эрсдэлийн үйл ажиллагааны чиглэлээр сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтныг компанийн бүтцэд оруулж батлан, хариуцсан мэргэжилтнийг томилон ажиллуулж байна       |
| 4 | Дотоод аудитыг Олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлээгүй                                                                                                                                | Толгой болон охин компаниудын дотоод аудиторуудын нэгдсэн сургалтыг 2019 онд зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгаж, цаашид аудиторуудыг мэдлэг, боловсролыг олон улсын стандартад нийцүүлэх зорилт тавин ажиллаж байна. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Дотоод аудиторуудын нэгдсэн чуулган, арга хэмжээнд толгой болон охин компанийн аудиторуудыг тогтмол хамруулж байна                                                       |
| 5 | Группийн хэмжээнд мэдээлэл солилцоо, харилцан хамааралтай ажиллах тогтолцоо хангалтгүй                                                                                                     | Группийн хэмжээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх Удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх тендер сонгон шалгаруулах үйл явц явагдаж байна. Энэхүү системийг нэвтрүүлснээр мэдээлэл солилцох урсгал сайжирна                                                                                                                                                                                                                |
| 6 | Ажиллагсдын ажилд орох, гарах урсгалаас шалтгаалан урт хугацааны бодлого, хариуцлагын систем маш сул                                                                                       | Компанийн хүний нөөцийн стратеги, бодлогын баримт бичиг 2018 оны 4 дүгээр сард ТУЗ-өөр батлагдсан. Үүнтэй холбогдуулан охин компаниудад үйл ажиллагааны чиглэл өгч сургалтуудыг зохион байгуулсан.                                                                                                                                                                                                                                        |
| 7 | Охин компаниуд толгой компаниас санхүүжилт, хөрөнгө оруулалт хэлбэрээр зээл авч өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд зээлийн эргэн төлөлт, гадны санхүүжилт татах ажил удаашралтай | Төлөөлөн удирдах зөвлөл болон холбогдох бусад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсний үндсэн дээр охин компаниудад олгосон зээл, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн талаар Санхүүгийн үйл ажиллагаа, аудит мониторингийн хэлтэстэй хамтарсан шалгалтын тайланд тусгаж дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан. Дүгнэлт зөвлөмжүүдийн талаар толгой компаниас охин компани тус бүр дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. |

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дунд хугацааны /2019-2023/ бизнесийн стратегийн баримт бичиг ТУЗ-ийн 2018 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан. Энэхүү баримт бичгийн хэрэгжилтийг жил бүрийн бизнес төлөвлөгөөний төлөвлөлтийн дагуу гаргаж хангуулна.

Иймд дээр дурдсан холбогдох тайлбарын хүрээнд шаардлагатай зарим тодруулгыг тайланд тусгах арга хэмжээ авна уу.

Хавсралт 14 хуудастай

Хүндэтгэсэн,

ДАРГА



Г.БАЯСГАЛАН

## ҮАГ-ын тайлбар

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 10-ны 02/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн 8 тайлбарыг судалж үзээд тайлангийн төсөлд дараах засвар өөрчлөлтийг орууллаа.

Аудитын явцад компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэхийг удаа дараа тодруулж, гэрчилгээг хуулбарлаж өгөхийг шаардсан боловч аудитын багт ирүүлээгүй, саналд хавсарган тул тайлангийн төслийн 1.18 дахь хэсэгт “Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д *“ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, одоогийн байдлаар ТУЗ-ийн нарын бичгийн дарга болон ТУЗ-ийн гишүүд гэрчилгээгүй ажиллаж байна” гэснийг хасав.

## “Эрдэнэс Монгол” ХХК-иас ирүүлсэн санал



### ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

14240 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Чингисийн өргөн чөлөө 15, Моннис тауэр, 15 дугаар давхар,  
Утас: 7555 3399, И-мэйл: info@erdenesmongol.mn,  
Вэбсайт: www.erdenesmongol.mn, УБД: 9011014002

2019.01.14 № 05/36  
танай \_\_\_\_\_ -ны \_\_\_\_\_ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

### Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01/2603 тоот албан бичгээр ирүүлсэн “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг орлогод гүйцэтгэлийн аудит хийж, тайлангийн төслийг ирүүлсэн ба тус төсөлтэй холбогдох саналаа үндэсний аудитын газарт хүргүүлэх” тухай мэдэгдсэний дагуу төсөлтэй холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>14</sup> хуудас

Хүндэтгэсэн,

САНХҮҮ ХАРИУЦСАН  
ДЭД ЗАХИРАЛ



Г.ГАНБОЛД

0000078

## **ҮАГ-ын тайлбар**

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 05/36 дугаар албан бичгээр ирүүлсэн 20 заалт бүхий тайлбарыг судалж үзэхэд аудитын тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах хэмжээний тайлбар ирүүлээгүй болно.



## Хавсралтууд

### Хавсралт 1. Дотоод хяналтаас өгсөн зөвлөмж, ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн талаарх судалгаа

| №  | Шалгалтад хамрагдсан байгууллагын нэр, шалгалт хийсэн огноо, ТУЗ-ийн тогтоолын огноо, дугаар        | Өгсөн зөвлөмжийн тоо | Зөвлөмжийн биелэлт     |                                                |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------|----------------------|------------------------|------------------------------------------------|
| 1  | Гашуун сухайт авто зам ХХК<br>2017.2.20-2017.3.10 хүртэл, ТУЗ-ийн 2017.3.30-ны 22 дугаар тогтоол    | 5                    | Тогтоолын танилцуулах  | хэрэгжилтийг дотор                             |
| 2  | Багануур ХК<br>2017.3.22-2017.4.14 хүртэл, ТУЗ-ийн 2017.5.30-ны 29 дүгээр тогтоол                   | 8                    | Тогтоолын танилцуулах  | хэрэгжилтийг дотор                             |
| 3  | Эрдэнэс Таван толгой ХК<br>2017.5.1-2017.5.20 хүртэл ТУЗ-ийн 2017.10.26-ны 43 дугаар тогтоол        | 11                   | Тогтоолын танилцуулах  | хэрэгжилтийг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан |
| 4  | Эрдэнэс Оюу толгой ХХК<br>2017.6.5-2017.6.16 хүртэл, ТУЗ-ийн 2017.10.26-ны 41 дүгээр тогтоол        | 6                    | Тогтоолын танилцуулах  | хэрэгжилтийг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан |
| 5  | Шивээ-Овоо ХК<br>2017.6.5-2017.6.9 хүртэл, ТУЗ-ийн 2017.10.26-ны 42 дугаар тогтоол                  | 6                    | Тогтоолын танилцуулах  | хэрэгжилтийг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан |
| 6  | Эрдэнэс Монгол ХХК<br>2017.6.26-2017.7.5 хүртэл, ТУЗ-ийн 2017.10.26-ны 2 дугаар тэмдэглэл           | 3                    | Хугацаа заагаагүй      |                                                |
| 7  | Эрдэнэс Шивээ энерги ХХК<br>2017.7.24-2017.8.5 хүртэл, ТУЗ-ийн 2017.10.26-ны 1 дүгээр тэмдэглэл     | 4                    | Хугацаа заагаагүй      |                                                |
| 8  | Гашуун сухайт авто зам ХХК<br>2017.9.12-2017.9.16 хүртэл, ТУЗ-ийн 2018.2.26-ны 3 дугаар тэмдэглэл   | 7                    | Хугацаа заагаагүй      |                                                |
| 9  | Мон-Атом ХХК<br>2017.11.13-2017.11.28 хүртэл, ТУЗ-ийн 2018.2.26-ны 3 дугаар тэмдэглэл               | 8                    | Хугацаа заагаагүй      |                                                |
| 10 | Эрдэнэс ассет менежмент ХХК<br>2017.12.1-2017.12.12 хүртэл, ТУЗ-ийн 2018.2.26-ны 3 дугаар тэмдэглэл | 1                    | Хугацаа заагаагүй      |                                                |
| 11 | Эрдэнэс метан ХХК<br>2017.12.1-2017.12.12 хүртэл                                                    |                      | Хурлаар хэлэлцүүлээгүй |                                                |

## Хавсралт 2. Дэд бүтэц, логиистикийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний биелэлтийн судалгаа

| № | Төслийн нэр                                                            | Эхлэх дуусах | Төслийн нийт өртөг                | Санхүүжилтийн эх үүсвэр      | Төслийн явц                                                             | Төслөөс гарч буй болон гарах үр дүн /хугацаагаар/  |
|---|------------------------------------------------------------------------|--------------|-----------------------------------|------------------------------|-------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|
| 1 | ТТ-Чойр чиглэлийн авто зам                                             | 2017-2021    | 425 тэрбум                        | Зээл                         | Урьдчилсан төсөв гаргасан                                               | ТЭЗҮ, зураг төслийн төсөв шийдвэрлэгдээгүй         |
| 2 | ТТ-Ханги чиглэлийн авто зам                                            | 2017-2021    | 348 тэрбум                        | Зээл                         | Урьдчилсан төсөв гаргасан                                               | ТЭЗҮ, зураг төслийн төсөв шийдвэрлэгдээгүй         |
| 3 | ТТ-ГС авто замын ШНЦ-1, 3-ыг сэргээгдэх эрчим хүчээр хангах төсөл      | 2017-2017    | 800 сая                           | Зээл                         | Нарны цахилгаан үүсгүүр ашиглалтад орсон                                | 2018-Нарны цахилгаан үүсгүүр хэвийн ажиллаж байна. |
| 4 | ТТ-ГС авто замын ШНЦ-2, 4-ийг сэргээгдэх эрчим хүчээр хангах төсөл     | 2018-2019    | 800 сая                           | Өөрийн хөрөнгө               | Урьдчилсан ТЭЗҮ хийсэн                                                  | Анхан шатны бэлтгэл ажил эхлээгүй байна.           |
| 5 | Гашуун сухайт боомтыг сэргээгдэх эрчим хүчээр хангах төсөл             | 2018-2019    | 6.6 тэрбум                        | Өөрийн болон зээлийн хөрөнгө | Урьдчилсан ТЭЗҮ хийсэн                                                  | Анхан шатны бэлтгэл ажил эхлээгүй байна.           |
| 6 | Уурхайн цахилгаан хангамжийн хэмнэлтийн загвар төсөл                   | 2018-2018    | Хөрөнгийн эх үүсвэр, шийдэгдээгүй |                              | Анхан шатны бэлтгэл ажил эхлээгүй 2018 оны бизнес төлөвлөгөөнөөс хассан |                                                    |
| 7 | Таван толгойн уурхайг сэргээгдэх эрчим хүчээр хангах ТЭЗҮ боловсруулах | 2018-2018    | Хөрөнгийн эх үүсвэр, шийдэгдээгүй |                              | Анхан шатны бэлтгэл ажил эхлээгүй 2018 оны бизнес төлөвлөгөөнөөс хассан |                                                    |
| 8 | ЭТТ уурхайгаас ТТ-ГС авто зам хүртэлх 8.2 км авто зам                  | 2017-2018    | 14.7 тэрбум                       | ЭТТ-70%, ЭМГЛ-30%            | Барилгын ажлын гүйцэтгэл-30%                                            | Ажлын хэрэгжилт дутуу                              |
| 9 | 520 автомашины зогсоол барих                                           | 2017-2017    | 5.6 тэрбум                        | Өөрийн хөрөнгө               | ХАА цуцлагдсан                                                          | Ажил хэрэгжээгүй байна.                            |

### Хавсралт 3. Охин, хараат компаниудын зорилго, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа

| Компанийг байгуулсан зорилго                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Хүрсэн үр дүн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>“Эрдэнэс Шивээ энерги” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ын 2016 оны оны 2 дугаар сарын 25-ны өдрийн тогтоолоор Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн 5280 Мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Хэрлэн голоос эх авсан усан хангамж байгуулах зэрэг эрчим хүчний цогцолборыг нүүрсээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ Шивээ” ХХК-тай хамтран байгуулсан. | 2018 оны байдлаар тус компанийн 50 хувийг “Эрдэнэс Монгол” ХХК, 50 хувийг “Э Кү Сора” ХХК тус тус эзэмшдэг бөгөөд үйл ажиллагаа эхлээгүй байна. “Шивээ энерги” төслийн нэгж 2016 онд байгуулагдсан бөгөөд 2017 онд ТЭЗҮ-ийг гэрээ хэлэлцээрийн дагуу Хятадын талаас хүлээж авсан боловч Эрчим хүчний яамаар батлуулаагүй, тодорхой үр дүнд хүрээгүй байна.                       |
| <b>“Эрдэнэс Метан” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, судалгаа хийх газрын тостой холбоотой үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт, холбогдох чиглэлээр зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, охин компани хэлбэрээр 2016 оны 2 дугаар сард байгуулсан байна.                                          | Тус компани Газрын тосны газарт 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдөр “Эрлийн гэрээ байгуулах хүсэлт гаргасан боловч тус газар татан буугдсанаар Монгол Улсын нүүрсний хийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөөт зорилтууд биелэгдээгүй, компанийн үйл ажиллагааны урсгал зардалд 2016 онд 207.5 сая төгрөг зарцуулж, 2017 онд 111.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. |
| <b>“Эрдэнэс ассет менежмент” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Засгийн газрын 2014 оны 133 дугаар тогтоолыг үндэслэн охин компани хэлбэрээр байгуулсан.                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>“Мон-Атом” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон, хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан.                                                                                                          | “Мон-Атом” ХХК байгуулагдсанаас хойш үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй, орлого байхгүй, их хэмжээний урт болон богино хугацаат зээлийн төлбөртэй байна. Тус компани цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байхгүй тул бусад хуулийн этгээдтэй хамтран 2 охин, 2 хараат компани байгуулсан боловч үр дүн гараагүй байна.                                 |
| <b>“Таван толгой түлш” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Засгийн газрын 2017 оны “Хөтөлбөр батлах тухай” 98 дугаар тогтоолыг үндэслэн “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх зорилгоор 2018 оны 5 дугаар сард байгуулсан.                                                                                                                                                                                  | Тус компани 2018 оны 10 дугаар сараас эхлэн шахмал түлш үйлдвэрлэж, борлуулалтад гаргах зорилгоор ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>“Эрдэнэс алт ресурс” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Монгол Улсын нутаг дэвсгэрт алт, мөнгийг өндөр сорьцтой цэвэршүүлэх үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор байгуулсан.                                                                                                                                                                  | 2018 онд үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах суурь судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх төлөвлөсөн байна.                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>“Эрдэнэс стийл” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Жилд 500.0 мянган тонн металлургийн кокс, 300.0 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, жилд дунджаар 448.3 сая ам.доллар буюу 8.1 тэрбум төгрөгийн борлуулалттай, 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, импортыг орлох бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах зорилготой байна.                                                                                     | Кокс, ган төмөрлөгийн үйлдвэрийн ТЭЗҮ, зах зээлийн тооцоог “Эрдэнэс Монгол” ХХК, “Бэрэн групп”-тэй хамтран боловсруулсан боловч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдаагүй, Төслийн нийт хөрөнгө оруулалт 320.0 сая ам.доллар бөгөөд гаднын хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй, үйлдвэр байгуулах газрын асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй.                                  |
| <b>“Эрдэнэс ашид” ХХК</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| “Эрдэнэс монгол” ХХК-ны төлөөлөн удирдах зөвлөлийн “Хамтарсан компани байгуулах эрх олгох тухай” 47 дугаар тогтоолоор ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх чиглэлээр “Эрдэнэс ашид” ХХК-ыг байгуулсан байна. Тус компани Баян Өлгий аймгийн нутаг дэвсгэрт орших 3 талбайд хийх геологи хайгуулын ажлаар үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөсөн байна.                                    | ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу “Эрдэнэс монгол” ХХК 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдөр “Эрдэнэс ашид” ХХК-ыг үүсгэн байгуулах тухай ЭМГЛ-20170213 тоот гэрээг “МАК” ХХК-тай байгуулсан боловч “Эрдэнэс ашид” ХХК хайгуулын тусгай зөвшөөрлөө эзэмшиж чадаагүй тул үйл ажиллагаа нь эхлээгүй байна.                                                                            |